



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОН 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	2-24
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	25-82
<hr/>	
1.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	26-33
2.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	33-36
3.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	36-38
4.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	38-39
5.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	39-40
6.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	40-43
7.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-55
8.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	55-72
9.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	72-82

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
07 дугаар сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 26 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг;

Тасалсан: Ш.Адьяаа, Ж.Батсуурь, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Б.Жавхлан;

Хоцорсон: Т.Аубакир-30 минут, С.Батболд-56 минут, Х.Болорчулуун-02 минут, Х.Булгантуяа-3 цаг 04 минут, Д.Ганбат-3 цаг 19 минут, Н.Ганибал-02 минут, Б.Дэлгэрсайхан-10 минут, Ш.Раднаасэд-04 минут, Ц.Сандаг-Очир-10 минут, Ж.Сүхбаатар-14 минут, Ц.Сэргэлэн-08 минут, Л.Энх-Амгалан-05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболороос ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ж.Батсуурь, С.Батболд нарт төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлж, баяр хүргэв.

Нэг.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамьянхүү, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Туваан, С.Чинзориг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн Үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Эдийн засгийн байнгын хорооны гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.11 дэх заалтын “тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8

дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 21

Бүгд: 44

52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эдийн засгийн байнгын хорооны гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 3.Эдийн засгийн байнгын хорооны гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “14.1,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 23

Бүгд: 44

47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 3.Эдийн засгийн байнгын хорооны гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “14.1,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна” гэж, мөн зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д заасны дагуу тогтооно” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар **Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.**

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн Ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт

зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн Үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	14
Бүгд:	41

65.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Жавхлан, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч Ц.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “суурь бүтэцтэй огтлолцох” гэснийг “суурь бүтэцтэй ижил бус түвшинд огтлолцох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “29.1.12” гэснийг “29.1.13” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах;

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29.1.1, 29.1.2, 29.1.3,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Жавхлан, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч Ц.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	16
Бүгд:	42

61.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа,

мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хууль санаачлагч байхгүй тул уг асуудлыг түр хойшлуулав./16:32/

Уг асуудлыг 16 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ж.Батжаргал, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 56 минутаас 17 цаг 17 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 20
Бүгд: 44
54.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд, мөн газрын Нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч А.Өнөржаргал, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Батжаргал, Ж.Чинбүрэн, Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 21 минутаас 17 цаг 25 минутад хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн Редакц, кодификацийн албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн /цаашид “Төсвийн байнгын хороо” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8.1.1¹ дэх заалтын дугаарыг “8.1.2” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.7¹ дэх заалтын дугаарыг “8.4.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8.1.1¹ дэх заалтын дугаарыг “8.1.2” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.7¹ дэх заалтын дугаарыг “8.4.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 10.5 дахь хэсгийн “санхүүжүүлэх, хянах, тайлагнахад төслийн кодыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэж, төсвийн төлөвлөлтөд тусгана.” гэснийг “санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхдээ төслийн кодыг үндэслэнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хэсгийн дугаарыг “11¹ дүгээр зүйл” болгон өөрчлөх:

**“11¹ дүгээр зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн
Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

11¹.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12².1-д заасны дагуу боловсруулсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хэсгийн дугаарыг “12² дугаар зүйл” болгон өөрчлөх:

“12² дугаар зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

12².1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 24.7 дахь хэсгийн “өмчийн оролцоотой” гэсний өмнө “төрийн болон орон нутгийн” гэж, мөн хэсгийн “ногдох хөрөнгийг” гэсний өмнө “болон орон нутагт” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 27.1.10 дахь заалтын “ирээдүйн өв сангийн дансны үлдэгдлийн мэдээллийг” гэснийг “Ирээдүйн өв сангийн үлдэгдлийн хэмжээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28¹.2 дахь хэсгийн “жил бүрийн 3, 8 дугаар сард багтаан” гэснийг “жил бүрийн 8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28¹.2.1 дэх заалтын “асуудал” гэсний өмнө “салбарын гэж нэмэн, 28¹.2.2 дахь заалтын “нийгмийн халамж, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин зэрэг” гэснийг болон 28¹.2.3 дахь заалтын “зэрэг шинжтэй” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28¹.3.Энэ хуулийн 28¹.2-т заасан төсвийн тодотголд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр боловсруулах төсвийн тодотгол хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28¹.4 дэх хэсгийн “төсөл, түүний нэмэлт, өөрчлөлтийн” гэснийг хасаж, “3 дугаар сард багтаан энэ хуулийн 28¹.1-д заасан журмаар” гэснийг “3 дугаар сард багтаан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 32.2.22 дахь заалтын “шийдвэрлэсэн талаар танилцуулгад тусгана.” гэснийг “тусгасан талаарх мэдээлэл;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийг хасаж, 70.2 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага болон

холбогдох” гэснийг “удирдах болон гүйцэтгэх” гэж, мөн хэсгийн “28^{1.3}” гэснийг “28^{1.4}” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8” гэсний дараа “, 28.3.12” гэж,” гэснийг хасаж, үүнтэй уялдуулан төслийн 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэснийг “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8-д” гэснийг “28.3.8, 28.3.12-т” гэж, мөн зүйлийн” гэж өөрчлөн, 2 дугаар зүйлийн ““санхүүжилтийн эх үүсвэрээр” гэсний дараа “анхны төсөвт өртөг, код” гэж” гэснийг ““төсөвт өртөг,” гэсний дараа “анхны төсөвт өртөг,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “55 дугаар зүйлийн 55.4.2 дахь заалтын “ирэх” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан”” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.3, 8.4.4, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг” гэснийг “дараах хэсэг, заалтыг” гэж, 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “заалтыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8.1.1 дэх заалтын “боловсруулсан” гэснийг “ирүүлсэн” гэж, “дүн шинжилгээ, тооцоонд” гэснийг “таамаглалд” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 8.4.3 дахь заалтын “, шаардлагатай тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн жилийн төсөвт баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тус тус боловсруулж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.4 дэх заалтын “холбогдох макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан нэгтгэн боловсруулж, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэхэд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэснийг “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “10-ны” гэснийг “9-ний” гэж өөрчлөн, “8.4.3 дахь заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “чуулган эхлэх өдрөөс эхлэн хэлэлцэн” гэснийг “чуулганаар хэлэлцэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “28.2,” гэснийг хасаж, “28.1” гэснийг “29.1” гэж өөрчлөн, “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.1.2-8.1.4 дэх заалтын дугаарыг “8.1.3-8.1.5” гэж, 8.4.8 дахь заалтын дугаарыг “8.4.9” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “түүний” гэснийг хасаж, “бүрийг кодоор” гэснийг “бүрийн код” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хууль, тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэлэлцээр батлахаас” гэснийг “хэлэлцээрээс” гэж, 2 дугаар зүйлийн “38.8 дахь” гэснийг “38.9 дэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.1 дэх заалтын “зээлийн зориулалт нь” гэснийг “зээлийн зориулалтыг тодорхой тусгасан эсэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцсэн эсэх” гэснийг “төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл, хөтөлбөр байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.3 дахь заалтын “Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх” гэснийг “улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт

болон зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.4 дэх заалтын “нөлөөлөхгүй” гэсний дараа “, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт” гэсний өмнө “хэсэг,” гэж нэмэн, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 6.4.8 дахь заалтын “зардлын хяналтыг” гэснийг “гүйцэтгэлийн хяналтыг” гэж өөрчлөн, 3 дахь заалт буюу 6.5.3 дахь заалтын “хэлэлцээр” гэсний өмнө, 5 дахь заалт буюу 13.2.5 дахь заалтын “хэлэлцээрийн” гэсний өмнө “гэрээ,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.5.4 дэх заалтын “Монгол Улс шинээр зээл авах” гэснийг “энэ хуульд заасны дагуу улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах” гэж, мөн заалтын “зэрэг мэдээллийг нэгтгэсэн байдлаар” гэснийг “зэргийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 18.11 дэх хэсгийн “тооцоолол” гэснийг “тооцоо, судалгаа” гэж өөрчлөн, “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнөх “Монгол Улсын шадар сайд,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “13.2.3” гэснийг “13.2.2” гэж өөрчлөн, 3 дугаар зүйлийн “тогтоосон” гэсний өмнө “талаар” гэж, “дэлгэрэнгүй” гэсний өмнө “талаарх” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмэн, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 8.8 дахь хэсгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн” гэснийг “Нэгдсэн төсвийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлэх” гэж” гэснийг “Монгол Улсын жилийн төсвийн” гэсний болон “жилийн төсвийн төсөлд” гэсний өмнөх “өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, заалт” гэснийг хасаж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 6.5 дахь хэсгийн “эцсийн хугацааг” гэснийг “хугацааг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 7.5 дахь хэсгийн “3 сараас доошгүй хугацаанд төсвийн төсөл” гэснийг “гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.6 дахь хэсгийн “Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гамшиг бүхий нөхцөл байдал бий болж төсөв болон” гэснийг “Гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах зорилгоор жилийн төсөв болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.7 дахь хэсгийн “хэлэлцэх Улсын Их Хурлын байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн чуулганд нийт гишүүн хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэснийг “хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.1 дэх хэсгийн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, “үзүүлэлтийн төсөөллийг” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16¹.2.Зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.3.2 дахь заалтын “идэвхтэй” гэснийг, 16¹.3.3 дахь заалтын “улс төрийн” гэснийг тус тус хасаж, 16¹.4.4 дэх заалтын “үр дүнгийн талаар сонсгол зохион байгуулж хамгийн өндөр үнэлэмж авсан” гэснийг “үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16¹.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэн, үүнтэй уялдуулан 16¹.4.5, 16¹.4.6, 16¹.4.7, 16¹.4.8 дахь заалт, 16¹.5, 16¹.6 дахь хэсгийг тус тус хасах:

“16¹.4.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.8 дахь хэсгийн “Төсвийн байнгын хорооны шийдвэрээр” гэснийг “Улсын Их Хурал” гэж, 16¹.9 дэх хэсгийн “үзүүлэлтийн тооцоолол” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж, 2 дугаар зүйлийн “үзүүлэлтийн төсөөлөлд” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд” гэж тус тус өөрчлөн, уг хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“16¹6.7.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.11 дэх хэсгийн “тогтоох итгэлцүүрийг” гэснийг болон 16¹.12 дахь хэсгийг тус тус хасаж, 16¹.3.7 дахь заалтын дугаарыг “16¹.10.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.3 дахь” гэснийг “8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь” гэж өөрчлөн, 8.3 дахь хэсгийн “дансанд” гэсний дараа “Сангийн эх үүсвэрийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “10.7, 10.8,” гэснийг “10 дугаар зүйлийн 10.8, 10.9 дэх хэсэг” гэж, мөн зүйлийн “24.15.5” гэснийг “25.14.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 5, 16, 21 дүгээр зүйлд хуульд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг,” гэснийг “, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг” гэснийг “болон төсвийн алдагдлыг” гэж тус тус өөрчлөн, мөн хэсгийн болон 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21 дэх хэсгийн “тусламж” гэсний дараа “, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ,” гэж тус тус нэмэн, 21 дэх хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэснийг “төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, төсвийн цаглаврыг мөрдүүлэхтэй холбогдсон зүйл, хэсэг заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төсвийн байнгын хороо гаргасан, Төслийн 1 дэх заалтын “16^{1.4} дэх” гэснийг “16¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хууль санаачлагч байхгүй тул уг асуудлыг түр хойшлуулав./19:08/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын урилгаар иргэний нисэх, төмөр зам, зам тээврийн салбарын үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 42 минут үргэлжилж, 73 гишүүнээс 51 гишүүн хүрэлцэн ирж, 69.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
15 цаг 26 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтган мэндчилье. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна. Арван асуудал хэлэлцэнэ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг;

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг;

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг;

Монгол Улс Азийн хөгжлийн банкны хооронд аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхийн хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төсөл;

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, хэлэлцэх эсэх;

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал;

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд;

10.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 24 саналтай. Энэ 10 хуулийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргахаар Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн албан бичиг ирүүлсэн байна. Ингээд Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлнэ.

Д.Өнөрболор: Энэ өдрийн мэндийг гишүүддээ хүргэе. Энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэхээр байгаа.

Тэгээд энэний гол асуудал нь энэ хуулиар дамжуулаад би Шинэ сэргэлтийн том бодлоготой зэрэгцээд өнөөдөр Улаанбаатар хотод түүхий нүүрсний утаа үйлдвэрлэх асуудал давхар орж ирж байгааг бас миний бие эсэргүүцэж байгаа юм. Энэ хорт утаа хотын иргэдийн уушги хоёроор би хонжоо олохыг бол үнэхээр эрс эсэргүүцэж эрс эсэргүүцэж байна. Зөвшөөрөхгүй.

Сая Төсвийн байнгын хороогоор хүч түрээд нэг хуулийг нь бол батлаад явчихлаа. Гишүүд та бүгд ер нь сайн мэдэж байгаа. Ер нь энэ гамшигийн хэмжээнд хүрсэн байж байгаа энэ хорт утаа Улаанбаатар нийслэлчүүдийн сүүлийн 10 жил сэдэв байж ирсэн. Үүнээс болж гэр бүл, үр хүүхдүүд, ард иргэд маань амь нас, эрүүл мэндээрээ өнөөг хүртэл хохирч ирсэн.

Тэгээд бид нар өнөөдөр ард иргэдэд ямар бэрхшээл учирч байна түүнийгээ шийдэхийн төлөө төр, Улсын Их Хурал, Засгийн газар энэ хууль тогтоомжийг баталдаг. Ер нь тэгэх ч ёстой гэж бодож байна. Тэгээд миний санал бол маш энгийн байсан юм. Энэ нийслэлд шинээр баригдах 1.5 мегаваттын дулааны эх үүсвэрт түүхий нүүрс ашиглахгүй байя. Өөрөөр хэлэх юм бол ард иргэдээ нүүрсээр хордуулахгүй эрүүл мэндийг нь амь насаар нь хохироохгүй байх ийм л энгийн заалт байсан. Ийм санаачилга байсан.

Гэтэл Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн болон энэ арга зүйн дэмжлэг үзүүлэх ёстой Тамгын газрын хуульч бол хууль, журам, дэгийн зохицуулалтыг ашиглаж үйлдэл, эс үйлдлээрээ иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийн эсрэг үгүй гэж хэлж байна. Өнөөдөр агаарын бохирдлоос болж жилд дунджаар 4000 гаруй хүн нас барж, харвалт, зүрх судасны өвчин, уушигны хавдар ийм амьсгалын замын өвчний шалтгаан болж байгаа. Уушигны хатгалгаагаар нас барж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь агаарын бохирдлоос үүдэлтэй. Өнөөдөр дэлхий дээр 100000 хүн тутамд ноогдох агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын тоо өнөөдөр Монгол Улсад дэлхийн дунджаас 1.4 дахин их байна. Бодит байдал ийм ноцтой хэмжээнд байхад түүхий нүүрсний хэрэглээг зөвшөөрч байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж

заасныг зөрчиж ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг ийм гэмт үйлдэл хийж байна.

Тийм учраас энэ анхны хэлэлцүүлэг дээр ер нь Тэмүүлэн дарга энэ гаргасан миний зарчмын зөрүүтэй саналыг тодорхой хэмжээгээр хуулийн төсөлд тусгах арга зүйн зөвлөгөөгөөр ингээд хангаад явчихсан байх юм бол өнөөдөр энэ хуулийн төслийг бүхэлд нь дэмжихгүй байх асуудал, санал хэлэхээргүй байлаа.

Тийм учраас энэ эрчим хүчний сайд Чойжилсүрэн сайдаа та шинжлэх ухааны үндэслэлтэй, технологийн хувьд дэвшилтэт, байгаль орчин, ард иргэддээ ээлтэй ийм байдлаар судалгаагаа бүрэн хийгээд энэ хуулиа дахин өргөн барьж, шийдэх хэрэгтэй гэж бол би бас шаардаж байна.

Тиймээс энэ Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг зөрчсөн, ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын эсрэг энэ хуулийн төслийг дэмжихгүй байхыг гишүүд та бүгдээс уриалж байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль өнөөдрийн хэлэлцэх асуудлын жагсаалтад байхгүй учраас санал хураалт явуулахгүй. Тэгэхдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль яг тэр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй харин илүү хангагдаж байгаа гэж Засгийн газрын тайлбар байгаа шүү дээ тийм ээ. Шинэ техник, технологи оруулж ирээд энэ агаарын бохирдол, агаарын чанарыг сайжруулах тийм зорилготой хууль л гэж л тайлбартай байсан. Тэгээд энэ эрх зүйн дүгнэлт гарахаар шилжүүлсэн юм байна лээ. Тэгээд эрх зүйн дүгнэлт гарахаар л энэ яригдах байх. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгээ явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 6 сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 7 сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 7 сарын 5-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын

хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандахын Жамъянхүү, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Дэлэгнямдоржийн Мөнхболд.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Адьшаа, Туваан гишүүнээр тасаллаа.

Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Өнөөдөр хэдхэн хоногийн дараа Монголын ард түмэн үндэснийхээ баяр наадмыг тэмдэглэх ийм асуудалтай холбогдуулж Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын өнөөдөр баталж байна.

Энэ Үндэсний их баяр наадмын хууль батлагдаж байгаатай холбогдуулаад энэ Монгол Улсын Шадар сайдаас нэг асуулт асууя. Монгол Улсын Их Хурлын нэр бүхий 4 гишүүн Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж, өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн. Энэ асуудалтай холбогдуулж Үндэсний баяр наадмын хуулийн 10 дугаар зүйлд үндэсний баяр наадамд жороо морь уралдуулна гэсэн ийм хуулийн заалт өнөөдөр хэрэгжихгүй байгаа. Энэ асуудлаар Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоол гарсан. Энэ жилийн улсын баяр наадамд жороо морийг уралдуулах, түүнчлэн жороо морийг уралдуулсан уяачдын хөдөлмөрийг үнэлэгч улсын баяр наадамд уралдаж байгаа 6 насны бусад морьдын нэгэн адил уяачид нь зэрэг, цол олгох асуудлыг шийдэх энэ талаар ямар байр суурьтай байна. Энэ талаар би Улсын Их Хурлын удирдлага, баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга, энэ ажлын хэсгээс энийг асууж байна.

Монгол Улсын хуульд батлагдсан энэ жороо морины уралдааны уяачид цол, чимэг олгох асуудал өнөөдөр үндэсний өв соёлоо дээдэлсэн, морины соёл, түүнчлэн уяачдын хөдөлмөрийг үнэлэх ийм асуудал байгаа. Энэ асуудлыг энэ жилийн баяр наадмаар энэ жороо морийг уралдуулж цол, чимэг олгох асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг талаар хариулт авъя.

Г.Занданшатар: Хариулт Пүрэвжавын Сайнзориг. Сайнзориг дарга энийг зөв шийдчих. Тэгэхгүй бол хууль өргөн баригдчихаад байгаа юм. Тэгээд хууль хэлэлцэх комисс байхгүй. Цол, чимгийг нь олгоод ингээд таны саналын дараа, хариултын дараа. Зөв нүүдэл шийдэл гарга. 81 Сайнзориг.

П.Сайнзориг: Адъяаа гишүүний асуултад хариулъя. Өвөрмөц явдалтай адуу буюу энэ жороо морины уралдааныг баяр наадмын уламжлалт өдрүүдээр бас уралдуулж болох энэ хуулийн зохицуулалт байгаа.

Гэхдээ уяачдын бас цолыг олгох энэ асуудал дээр ямар насны, ямар морийг хэд хэдэн удаа айрагдуулсан, бүсийн наадамд хэдэн удаа айрагдуулсан, түрүүлүүлсэн

гэдэг энэ амжилтаар нь үнэлж энэ цолыг олгох зохицуулалт түрүү өмнөх жил батлагдсан Баяр наадмын тухай хуулиар оруулчихсан байгаа юм.

Ер нь уралдуулах асуудал нээлттэй байгаа. Энэний үр дүнг хүлээн зөвшөөрч цол олгох энэ тэр гэдэг асуудал бол бас бас хууль, эрх зүйн талаасаа бас жоохон тодорхойгүй буюу бид нар бас бас зайлшгүй энэ хууль, эрх зүйн орчин нь бүр бүрдүүлэх гэж байж бас шийдэх ийм асуудал гэдгийг бас хэлмээр байна.

Би таны хэлж байгаа саналыг бас Баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга, Шадар сайдад бас уламжилъя. Тэгээд яг хурдан морины уралдаантай холбоотой дүрмийг бас Засгийн газрын тогтоолоор баталдаг, бүсийн наадмуудын бас хуваарийг бас Засгийн газрын тогтоолоор баталж байгаа.

Тэгэхээр бид хэд бүгд энийгээ уялдуулж харж бас танд эргээд бас хариу өгье.

Г.Занданшатар: Ширнэнбаньдийн Адъяаа гишүүн тодруулж асууна.

Ш.Адъяаа: Энэ жороо морь уралдуулах асуудал Үндэсний баяр наадмын хуулийн 10 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн байгаа. 1996 оноос хойш энэ жороо морийг 13-ны өдөр уралдуулж ирсэн ийм түүхэн уламжлалтай шүү дээ. Тэгээд яагаад энэ улсын баяр наадмаар энэ жороо морь уралдуулсан хүмүүст уяачид нь цол, чимэг өгөх энэ асуудлыг шийдэж яагаад болохгүй байна вэ. Энэ дээр бас тодорхой хариулт авъя. Энэ бол нэгэнт Улсын баяр наадмын тухай хуульд ингээд орчихсон асуудлыг 1996 оноос хойш өнөөдрийг хүртэл ингээд жороо морийг уралдуулаад ирсэн адууны соёл, өв уламжлалын асуудлыг ингээд орхигдуулсан байдалтай, үл анзаарсан байдалтай ийм байх нь бас ингээд бид адууны соёлыг, соёлын сэргэлт гэдэг ийм юмыг энэ төр засгаас явуулж байгаа шүү дээ. Энэ талаар бас нэмж хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Үндэсний их баяр наадмын асуудлыг хуульчилж энэ үндэсний өв соёл, бидний ахуйтай холбоотой энэ уламжилж ирсэн соёлыг бас түгээн дэлгэрүүлэх асуудал дээр онцгой анхаарч байгаа. Түрүү жил батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10,19 дүгээр зүйлд их баяр наадмаар Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдаан зохион байгуулж болно гээд энэ уралдааныг зохион байгуулах асуудал бол нээлттэй байна.

Харин тус хуулийн 10 дугаар зүйл дээр үндэсний хурдан морины уралдааныг Монгол үйлдвэрийн адууны стандартад нийцсэн морийг азарга, их нас, соёлон, хязаалан, шүдлэн, даага гэсэн 6 насны ангиллаар зохион байгуулж эдгээр насны ангиллуудаар уралдуулсан Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл болон бүсийн үндэсний хурдан морины уралдаан, Үндэсний их баяр наадмын амжилтуудыг үндэслэж байж уяачдад цол олгох асуудал бас хуульчлагдсан байгаа.

Тийм учраас бас танд.../минут дуусав./

Г.Занданшатар: Сайнзориг дарга Комисс дээрээ яриад энэ Амарсайхан сайд хаана байна. Энэ уяачдад биш жороо морь нь Онцгой комисс хуралдаад за за. Тэр жороо морь чинь бас Монгол өв соёл, наадмын өв, соёл тэрийг бас Засгийн газрын түвшинд цол, чимэгтэй болгож шийдээд, Засгийн газрын хуралдаанаараа шийдчихсэн үү. Тийм үү Засгийн газрын хуралдаанаар шийдээд бас цол чимэг, өргөмжлөл олгоод бас л өв, соёлын төрөл, аялал жуулчлал олон нийтэд таниулах ч гэсэн бас морины соёл гэдэг чинь Монголчуудын эрхэмлэдэг соёл шүү. Тэгээд энийг ингээд дэмжээд явуулчих тийм чиглэл, бодлоготойгоор энэ хууль батлагдаж байна гэж ойлгоорой.

Тэгэхгүй бол 2 хоногийн дотор Засгийн газар дэмжээд санал өгчихсөн юм байна лээ. Тэгээд 2 хоногийн дотор энэ хуулийг баталж амжихгүй болчихоод байна. Өнөөдөр л санал нь ирж байна.

Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал орж ирлээ. Тэгээд удахгүй Монголчууд дэнж хотойтол сайхан наадах энэ наадмын цаг хугацаа тулж ирж байна. Тэгэхээр энэ хуулиа бас хурдан батлаад, гаргаад явуулчихсан нь дээр байх. Энэ дээр ажлын хэсгээс хэд хэдэн тодруулах асуулт байна. Энэ аймаг, сумын баяр наадмыг нэгэн зэрэг 10, 11-ний өдөр тэмдэглэнэ гээд хуульд байгаа тийм ээ. Тэгэхээр зарим газар аймгийн Засаг дарга Засгийн газрын шийдвэр гараад ингээд наадмын товууд өөрчлөгдөж байна.

Тэгэхээр энэ үндэсний бөх, бөхийн барилдаан болно. Энэ дээр тэр цол өгөх асуудал нь яах юм бэ. Цол өгөх асуудал нь өөрчлөгдсөн хугацаагаар явсан наадмууд дээр цол өгөх үү. Энэ цолны асуудлыг тодорхой болгож өгөөч.

Энэ аймгийн наадам дээр энэ 256 бөх барилдахыг ингээд энэ дээр оруулж ирж байна. Сумын наадамтай холбоотой ер нь ямар асуудал орж ирж байгаа юм. Энэ чинь тэгш ой хийж байгаа сум дээр чинь 128 энэ тэр бас барилдах боломжийг нээж өгөх энэ асуудал яг энэ өөрчлөлтөд оруулаад ирж болоогүй юу. Нэгэнт аймгийг нь оруулж ирчхээд сумыг нь орхиод явчихсан нь ямар учиртай юм бэ.

Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Энэ сая хэд хоногийн өмнө энэ улсын бөхийн сорилго барилдаан Бөхийн өргөөнд боллоо л доо. Тэгээд энэ сорилго барилдааны үеэр Төв аймгийн Мөнгөнморьт сумын 100 жилийн ой болж байгаа. Тэгээд энд Монгол Улсын арслан цолтой байсан Чимэд гэдэг хүнд аварга цолны батламжийг Монголын Үндэсний бөхийн холбооноос олгосон. Энэ ямар

учиртай гэхлээр 1934 онд 1024 бөхөд 9 давж үзүүлэсэн, 35 онд 1024 бөхөд 10 давж түрүүлсэн, 36 онд 1024 бөхөд 9 давж үзүүлэсэн. Ингээд нийтдээ 9-ийн давааг 4 удаа давчихсан. Одоогийн амжилтаараа энэ хүн Дархан аварга цол авах хэмжээний амжилт үзүүлсэн ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ асуудал яаж шийдэгдэх гарц, гаргалгаа байна. Энэ хууль дээр ямар гаргалгаа байна гэдгийг бас тодруулж асуумаар байна.

Дээрээс нь энэ уржнан жил болж байна. Энэ Хүй долоо худагт болсон Ардын хувьсгалын яг жинхэнэ 1921 оноос тооцвол яг жинхэнэ 100 жилийн ой дээр бөхийн барилдаан болсон. Энэ барилдаан дээр улсын заан Бат-Өлзий, мөн Ууганбаяр манай Төв аймгаас түрүүлж үзүүлэсэн байдаг. Энэ асуудал чинь яг жинхэнэ 100 жилийн хугацаандаа болсон энэ асуудал дээр цааш нь цол, чимгийг нь олгох асуудал энэ удаагийн хуулийн өөрчлөлтийн үеэр хөндөгдөх үү, ямар шатдаа явж байгаа вэ гэсэн асуулт байна.

Дээрээс нь энэ морьтой холбоотой, хурдан морьтой холбоотой асуудал сүүлийн үед ер нь энэ уяачид, морь уядаг хүмүүсийг хавар, намар уралдах энэ тэр асуудал дээр нь нэлээн тийм хавчих ийм байдалтай болж байна л даа. Тэгэхээр энэ чинь өөрөө үндэсний маш том өв, соёл ингээд яваад байгаа.

Тэгэхээр энийг харин дэмжмээр асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр ямар асуулт асуух гэж байна гэхлээр нөгөө 2025 он чинь 2 хоноод л, 2 унтаад л ер нь болно. Тэгэхээр энэ морины бүртгэлтэй холбоотой асуудлыг 1 жил гарангын хугацаа өнгөрлөө Сайнзориг даргаа. Энэ ямар байдлаар, өөрөөр хэлбэл энэ морины бүртгэл 2025 оноос хэрэгжүүлж эхлэх энэ асуудал чинь ямар шатдаа явж байна. Гарсан ахиц байна уу гэсэн ийм асуултуудад тодорхой хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Хариулт
Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Ерөнхийдөө баяр наадмуудыг бас зунжингаа хавтгайруулж хийхгүй байх үүднээс ер нь нэгэн зэрэг тэмдэглэдэг байя гэдэг энэ зохицуулалтыг түрүү жил Үндэсний их баяр наадмын тухай хуулиар баталсан.

Энэ хүрээндээ бас аймаг, сумууд маань наадмаа 7 сарын 10, 11-ний өдрүүдэд бас хуваарилж тэмдэглэхээр ер нь зохицуулалт байгаа. Үнэхээр онцгой нөхцөл байдал буюу гамшиг, эргээд энэ гантай ч гэдэг юм уу ийм нөхцөл байдлуудаас шалтгаалж бас баяр наадмуудыг 8 сарын 10-ндаа багтаагаад бас тодорхой өөр өдрүүдэд зохицуулах ийм заалт байгаа.

Гэсэн хэдий ч бас энэ хуулийг бас сурталчлан таниулах асуудал бас хангалтгүй байна гэж үзэж байгаа бас тодорхой хэмжээнд. Бас аймгууд ялангуяа сумууд ингээд дур дураараа наадмаа өөр өдрүүдэд зохион байгуулж байгаа. Үүний үр дагавар нь тухайн тэр наадмын үр дүнгээр, үр дүнг бас хүлээн зөвшөөрөх асуудал их маргаантай болж хувирна. Энэ асуудлыг эцэслэн шийдэх газар нь Үндэсний бөхийн холбоо байж байгаа хуулиараа. Энийг ийм хариултыг танд өгмөөр байна.

Хоёрдугаарт наадмыг нэгэн зэрэг зохион байгуулдагтай холбоотойгоор сумуудад 64, аймгуудад 128 бөх барилдахаар түрүү жил хуульчилсан. Ер нь зүгээр тэгш ойн тэмдэглэлт өдрүүд дээр аймгуудад энийг 256 бөх барилдаж болохоор энэ удаагийн өөрчлөлтөөр орж ирж байгаа. Сумыг энэ удаагийн өөрчлөлтөөр хөндөөгүй гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Өмнө нь тэр Ардын хувьсгалын ойн жилүүдэд энэ баяр наадмыг хуульчлахаас өмнө зарим хүмүүсийн амжилтыг бас дутуу үнэлсэн ийм асуудал нэлээдгүй олон хүмүүс дээр яригддаг. 2003 онд Үндэсний их баяр наадмын хуулийг хуульчлахдаа цолыг нэхэж олох асуудал байхгүй гэдэг зүйлийг ингээд хуульчилчихсан юм байна лээ. Тэгэхээр юу гэдэг юм амьд, мөнх

бусыг үзүүлсэн тэр хүмүүст цолыг нэхээж олгох асуудал одоогоор хууль, эрх зүйн хувьд боломжгүй байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Дээрээс нь 2021 онд Залуучуудын холбооны зохион байгуулсан баяр наадамд амжилт үзүүлсэн бөхчүүдэд цол олгох асуудал хууль, эрх зүйн хувьд боломжгүй. Өөрөөр хэлэх юм бол энэ бол Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулаагүй. Засгийн газар баяр наадмыг хойшлуулсан шийдвэрийг гаргасан. Түрүү жил 100, 101 жилийг хамтатган тэмдэглэх ийм шийдвэр гарсан байгаа.

Тэгэхээр 21 онд болсон наадмыг яг 100 жил гэж, 100 жилийн наадам гэж олгох асуудал боломжгүй байгаа. Тэгэхээр энийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо болон бөхийн салбар хорооноос эдгээр наадамд буюу Залуучуудын холбооны зохион байгуулсан 21 оны наадмын үр дүнг тооцож цол олгох боломжгүй гэдэг хариугаа бид нар өгсөн байж байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулна.

Ц.Туваан: Энэ морины бүртгэлийн асуудал юу болж байгаа талаар бас мэдээлэл байвал өгчихмөөр байна. Тэгээд нэмж асуух асуулт нь тэр энэ тэгш ойттой аймгууд байгаа шүү дээ. Анх үүсэн байгуулагдсан 4 аймаг тухайлбал тэр дотор Төв аймаг ороод явж байгаа. Тэгээд бүсийн наадмын эрхээ давхар авчихсан явж байгаа. Тэгээд бөхийн гал дээр очихоор бөхчүүд бас энэ 256 болгож байгаатай холбоотой, ер нь энэ цол олгох барилдаанаа алийг нь албан ёсны цол олгох барилдаан гэж үзэх вэ энэ тэр гээд энэ нэлээн тийм тодорхойгүй асуулт байна гээд байна лээ. Энэ дээр яг яаж олгох юм гэдэг дээр нь ажлын хэсэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Г.Занданшатар: 81 Сайнзориг. Пүрэвжавын Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Морины бүртгэлтэй холбоотой тодруулгыг өгье. Өнөөдөр бас Засгийн газрын хуралдаанаар бөхийн болон морины уралдаантай холбоотой дүрмийн өөрчлөлтүүд орсон. Морьтой холбоотой хэмжиж байгаа энэ асуудал дээр бас маргаан дагуулж байсан асуудлыг улам нарийвчилж барианы зурхайгаас гарахаас нь эхлээд уралдаж орж ирсэн айргийн 5 морины бас шүдлэгийг дахин давхар хийж баталгаажуулах, морины бүртгэлийг бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд ил, тодоор хийх зэрэг ийм өөрчлөлтүүд орж байгаа. Энэ зүйлийг бас танд хэлмээр байна.

Тэр 256 тэгш ой зохион байгуулахтай холбоотойгоор өнөөдрийн баяр наадмын хуулийн өөрчлөлттэйгөөр 256 бөх барилдах энэ асуудал бол зөвхөн наадмын холбоотойгоор орно. Өөрөөр хэлэх юм бол тухайн яг хуулийн дагуу, тухайн аймаг дээр зохион байгуулагдаж байгаа улсын баяр наадамд 256 бөх барилдаж үүний үр дүнг үндэслэж цол олгох асуудал.../минут дуусав./

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга гүйцээж хариулъя 81.

П.Сайнзориг: Тийм, олгох бөгөөд үүнтэй холбоотойгоор яг үзүүлсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгох энэ жишгээрээ явна гэдэг зүйлийг бас танд хэлье.

Г.Занданшатар: Гүйцэгдсэн үү. Туваан гишүүн. Ойлгосон Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Баяр наадмын хуульд .../үг тасрав.

Г.Занданшатар: Байнгын хороо ер нь эцсийн хэлэлцүүлэг дээр огт хамаагүй юмнууд асуугаад байна гэж анхааруулж байна шүү. Энийг гишүүд анхаар.

С.Чинзориг: Баяр наадмын тухай хуульд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор хоёр зүйл тодруулах зайлшгүй шаардлага байгаа юм. Нэг дэх асуудал нь өнгөрсөн жил Баяр наадмын тухай хуулийг батлахдаа энэ морины уралдааныг үг хэлгүй, хэрүүл шуугиангүй болгодог, болгох тухай асуудал нэлээн яригдсан. Хөдөөгийн малчид бол Монгол адуугаараа уралдмаар байна гэдэг. Төв суурин газрын мөнгө хөрөнгөтэй болчихсон уяачид нь эрлийз адуугаар уралддаг бөөн хар хэрүүл болдог. Наадам хийж чадахаа байсан.

Тэгээд өнгөрсөн жил Баяр наадмын тухай хуульд чинь Монгол адууны стандартыг боловсруулж, батлуулна гээд орсон шүү дээ. Тэгээд энэ батлагдаад гараад ирэхлээр энэ хэрүүл тэмцэл гайгүй болно гэж л ярьсаар байж байгаад л Баяр наадмын хууль батлагдсан. Одоо тэгээд Монгол адууныхаа стандартыг боловсруулж оруулж ирэх асуудал нь байдаггүй. Чимээгүй. Тэгээд өмнөх будилаан нь хэвээрээ л үргэлжлэх юм уу. Зөвхөн сэрвээний өндрөөр хэмжиж уралдуулна гэхлээр чинь хөдөөгийн Монгол адуутай энэ малчид баяр наадмаараа сайхан баярлаж, цагийн хатууг даван туулсныхаа баяр наадмыг хийж чадахгүй ингээд л асуудал үргэлжлэх нь л дээ.

Тэгэхээр энэ асуудал хэзээ шийдэгдэх юм бэ. Тэр Монгол адууны стандарт гэж юм чинь байна уу, үгүй юу. Хэзээ боловсруулж байгаа юм, хэзээ орж ирж батлагдах юм. Тэгээд энэ хөдөөгийн малчид яаж энэ Монгол адуугаараа сайхан үг хэлгүй уралдаж, наадаж болох нөхцөл бололцоог нь бүрдүүлэх гэж байгаа юм.

Хоёр дахь асуудал нь 2021 онд Хүй долоо худагт чинь 512 бөхийн барилдаан зохион байгуулсан байдаг. Энэ бөхийн барилдааныг зохион байгуулахдаа яг л Үндэсний баяр наадмын бөхийн барилдаан зохион байгуулдаг дүрмээр явуулсан, бүх бөхчүүдийг допингийн шинжилгээнд хамруулсан байдаг. Одоо 5 давсан, 7

давсан, 9 давсан бөхчүүдэд нь цол олгох юм байна гээд баахан шуугьсан. Одоогоор энэ асуудал шийдэгддэггүй.

Гэтэл бол тэгш бус хандсан гээд иргэдийн дунд асар их яриа байгаа шүү дээ Сайнзориг даргаа. Тэр 2001 онд Хүй долоо худагт болсон баяр наадмаас маш хурдан морины уралдаан уралдсан. Тэр морины уралдаанд нь айрагдсан адуунуудад нь амжилтаар нь үндэслээд бас нөгөө уяачдынх нь цол чимгийг өгчихсөн гэдэг гэдэг. Уяачид нь цол чимгийг нь өгсөн атлаа бөхийн барилдаанд амжилттай барилдаж, цолны болзол хангасан бөхчүүдэд нь цол олгохгүй байна гэдэг асуудал одоогоор яриад байдаг. Энийг тэгээд нэг тийш нь шийдмээр байна. Би бас мартаагүй бол өнгөрсөн жилийн Баяр наадмын хууль батлахдаа Журмын тухай хууль гэж баталсан шүү дээ. Энэ журмын тухай хуулиар 1 удаагийн цол өгөх арга хэмжээг зохицуулах ийм зохицуулалт оруулж Журмын тухай хууль баталсан. Тэгээд энэ журмынхаа тухай хуулийг хэрэгжүүлээд энэ Бөхийн холбоо тэр 2001 онд болсон наадамд амжилттай барилдаж цолны болзол хангасан залуучуудад цол олох арга хэмжээг нь авч өгдөггүй юм уу. Энэ чинь тэгээд л 2 жил л дамнагдаад л ингээд яригдаад. Тэр 5 давсан, 7 давсан залуучууд нь цол авна гээд л. Ингээд бүгдээрээ л допингийн шинжилгээ өгөөд л маш их, асар их үг хэлтэй ийм л наадам болсон шүү дээ.

Тэгсэн атлаа уяачид нь болохлоор амжилтыг нь үндэслээд цол олгох тэр уралдааны төрөлд нь багтаагаад ингээд цол олгочихсон гээд л одоо үг хэлтэй байдаг. Уяачид нь болохоор цол олгож болоод байдаг, бөхчүүд нь цол олгож өгч болдоггүй. Ингээд Монгол төр уяачид, бөхчүүддээ ялгамжтай хандаж байна гэдэг ийм л асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн жилийн тэр баталсан Баяр наадмын хуулиа дагуулж батлагдсан Журмын тухай хуулийг хэрэгжүүлэх юм уу, хэрэгжүүлэхгүй юм уу. Тэр хэрэгжих үндэстэй хууль гаргасан юм уу.

Хэрвээ үндэстэй бол хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхгүй бол тэрийгээ хүчингүй болгодог юм уу ингээд олон түмэн хүлээлт хүссэн асуудлыг нэг тийш нь шийдчихмээр л байх юм.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга. 81 хариульга.

П.Сайнзориг: Ерөнхийдөө бас Үндэсний их баяр наадамд уралдаж байгаа энэ адууны цус сэлгэлт ер нь хаа сайгүй л нэлээн явчихсан юм байна лээ. Тэгээд энэ стандартыг батлахдаа ер нь сэрвээний өндрөөр л явахгүй бол бас болохгүй байна гэдэг зүйлийг бас уяачид маань ярьж байгаад ийм шилжилтийн зохицуулалт хийсэн.

Ер нь зүгээр цаашид бас энэ Монгол адууны стандартыг шинэчлэн батлуулах асуудал Засгийн газар, тэр дундаа хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яамны ажил байгаа. Энийг ингээд Хүнс, хөдөө аж ахуйн яам маань бас тодорхой хэмжээний судалгаа шинжилгээний үндэстэйгээр хийх байх. Тэгэхдээ энэ өөрөө эргээд энэ цаг хугацаа шаардсан, зардал шаардсан ийм нүсэр ажил гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Хоёр дугаарт энэ допингтой холбоотой асуудал байна. Энэ дээр бас тодорхой хэмжээний допингийн эсрэг үндэсний дүрмүүд батлагдаж хэрэгжээд явж байгаа. Бид ч гэсэн энийг цаашид улам сайжруулах энэ асуудал байгаа гэдэг зүйлтэй тантай санал нэг байна.

Ер нь зүгээр тэр 21 оны Залуучуудын холбооны зохион байгуулсан наадам бол Засгийн газрын шийдвэргүй байгуулсан, зохион байгуулсан наадам. Энийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо юм уу, салбар хороо шийдэх эрх хэмжээ байхгүй. Харин түрүү жил Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах, Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль баталсан. Дагаж мөрдөх

журмын хууль дээрээ үндэс Монголын үндэсний бөхийн холбоо 100, 101 жилийн ойг тохиолдуулан энэ асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлээрэй гэсэн.

Гэтэл өнөөдөр Дагаж мөрдөх журмын хуулийн хугацаа үндсэндээ дуусаж байна гэсэн үг. 100, 101 жилийн ойг тохиолдуулан гээд тухайн цаг мөч дээрээ хэрэгжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад хандаагүй. Тэгэхээр бид хэдээр юу гэдэг юм Засгийн газарт ч юм уу эсвэл Шадар сайдад хандаж энэ асуудлыг шийдэх бололцоо байхгүй. Энийг бас Үндэсний бөхийн холбоо, эрх бүхий байгууллага буюу Ерөнхийлөгчийн институтэд уг нь асуудлаа тавьж шийдвэрлүүлэх бололцоо байсан гэж зүгээр харсан.

Тэгэхдээ цаг хугацааны хувьд 100, 101 жилийг ойг тохиолдуулан гэж байсан. Тэгэхээр энэ цаг хугацаа өнгөрсөн учраас эдгээр бөхчүүдэд цол олгох асуудал байхгүй гэдэг зүйлийг л хэлэх нь зөв байх.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.

15.58 цаг

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч

Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.
Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагааг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй 2 саналын томъёололд бэлтгэснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд орсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч, ажлын хэсгээс санал хураалтаар бэлтгэсэн хууль зүйн техникийн шинжтэй зарчмын зөрүүтэй 2

саналын томъёоллыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд, хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Иргэний нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Зам тээврийн, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Зам тээврийн, хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Чимэддоржийн Мөнхтуяа, Зам тээврийн, хөгжлийн сайдын зөвлөх Доржийн

Эрдэнэбат, Иргэний нисэхийн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга Пүрэвжавын Ганболд, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Нямсамбуугийн Батсайхан, Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер Зинамидарийн Туяа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж дэмжсэн санал.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.11 дэх заалтын “тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хэрэгжүүлэх” гэж, 12.1.11 дэх заалтын “тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг хасах. Санал

гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Зам тээврийн, хөгжлийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар иргэний нисэх, төмөр зам, зам тээврийн салбарын үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт замчдадаа зам тээврийн салбарынхандаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс алтан шар замчин өлзийтэй байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх заалтыг 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5, 12.1.6 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд зам тээврийн салбарынхан, иргэний нисэхийнхэн, төмөр замынхан, авто замынхан, зам тээврийн салбарын үе үеийн удирдлага, зүтгэлтнүүд та бүхэндээ сайн сайхныг хүсье. Баярлалаа.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “14.1,” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Манай Бямбацогт сайд бас 2 хуулийг чуулганы төгсгөлд маш хурдтай батлуулж чадлаа шүү. Энэ салбарынхан бас их азтай салбар юм даа бас л.

Г.Занданиатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Саяын саналын томьёоллыг дэмжиж санал өгсөн юм. Эсрэг гарчихлаа. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү гэж хүсэж байна. Дараад байсан гараагүй.

Г.Занданиатар: Энэ тэгээд хасахгүй байсан ч гэсэн их хорттой заалт биш л дээ. Төрийн захиргааны байгууллага Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлнө гэж байгаа биз дээ. 15.5 дахь хэсгийнх юм уу. 15.5-д. Санал хураалт явуулъя. Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

65.9 хувийн саналаар санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон тул санал хураалтыг дахиж явуулъя.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ 15.5 дээр чинь 14.1 гэсэн заалт төсөл дээр байхгүй байгаа байхгүй юу. Айн айн. Төслийн 15.15 гэж байгаа шүү дээ. Анхны хэлэлцүүлгээр дэмжсэн бол төслийн гэж явахгүй шүү дээ.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

42.2.3 дахь заалтын дагуу санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна” гэж, мөн зүйлийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д заасны дагуу тогтооно” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. Чи наад шийтгэсэн хувилбараа өг л дөө тэгээд.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

16.10 цаг

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 3 дугаар сарын 30-ны, 4 дүгээр сарын 6-ны, 4 дүгээр сарын 27-ны, 6 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд чуулган

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийн 9 дүгээр зүйл Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг өөрчлөхөөр тусгасан боловч тус зохицуулалттай холбогдуулан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хуулийн төслийн хамт өргөн мэдүүлээгүй орхигдуулсан тул тус Байнгын хороо Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар уг тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын

зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 29.22-т заасныг баримтлан тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд орсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг өмнөхтэй адил. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төмөр замын хуулиар орчхож. Асуулт, хариулт байхгүй.

Байнгын хороо тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Иргэний нисэхийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төсөл хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар

Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орёё.

16.15 цаг

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 3 дугаар сарын 30-ны, 4 дүгээр сарын 6-ны, 4 дүгээр сарын 27-ны, 6 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийлээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч ажлын хэсгээс дахин санал хураалгахаар бэлтгэсэн хууль зүйн техникийн шинжтэй зарчмын зөрүүтэй 3 саналыг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд, хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хууль, төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Зам тээврийн, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Хүчитбаатарын Итгэлт, тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын хэрэгжилтийн дарга Дагвын Жавхлан, тус яамны Хуулийн хэлтсийн дарга

Сүхээгийн Мяндасмаа, тус яамны Төмөр, зам далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч Цэрэнгийн Наранчимэг.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Асуулт түрүүн асуусан. Асуулт байхгүй гэсэн шүү дээ. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуусан байхгүй гэсэн. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “суурь бүтэцтэй огтлолцох” гэснийг “суурь бүтэцтэй ижил бус түвшинд огтлолцох” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Чуулганы дэгийн тухай, гүйцээн боловсруулах санал өгсөн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хурааж дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “29.1.12” гэснийг “29.1.13” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах;

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29.1.1, 29.1.2, 29.1.3,” гэснийг хассугай.”. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. Гишүүд суудалдаа суу. Санал хураалт унах гээд байна шүү наана чинь.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Төмөр замын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр санал хураалт явуулж.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, сая хураачихсан байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж явуулж дууслаа. Хассугай гэж санал хураасан байсан шүү дээ.

Ингээд Төмөр замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Энэ дандаа эцсийн хэлэлцүүлгүүд учраас.

16.20 цаг

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн

анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 3 дугаар сарын 30-ны, 4 дүгээр сарын 6-ны, 4 дүгээр сарын 27-ны, 6 дугаар сарын 28, 29-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийн 10 дугаар зүйлд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын талаар тусгасан боловч тус байгууллагатай холбогдуулан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн өөрчлөлт, бүдүүвчийг шинэчлэх тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар сарын 07 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хуулийн төслийн хамт өргөн мэдүүлээгүй орхигдуулсан тул тус Байнгын хороо “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар уг тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргаагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Нийгмийн даатгалын багц хуультай холбоотой үгийг аваад ирээч. Ажлын хэсэг түрүүчийн хууль, тогтоолын төслийн ажлын хэсэгтэй овог нэр, ажил, албан тушаал адил. Протоколд тэмдэглэе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хороо тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоол төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй хамт эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё

16.23 цаг

Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам тээврийн, хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт гарын үсэг тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв болон Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороодоор тус тус хэлэлцэн дэмжсэн.

Үүний дагуу Ерөнхий сайдын 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар захирамжаар Сангийн сайдад тус санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгосны дагуу Азийн хөгжлийн банктэй 2 дугаар сарын 28-ны өдөр хоёр талаас хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол болон Шинэ сэргэлтийн бодлогод хөдөөгийн сэргэлт гэсэн Монгол Улсын дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нягт нийцэж байгаа бөгөөд хүнсний 19 гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болоход чухал ач холбогдолтой төсөл юм.

Цаашилаад тус хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

Нэгдүгээрт нь аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг хөгжүүлэх. Үүнд төвлөрсөн дулаан хангамж, ус зайлуулах хоолой, бохир усны хоолой зэрэг аймаг, сумын дэд бүтцийн дутагдлыг шийдвэрлэхэд 395.7 сая доллар.

Хоёрдугаарт нь агро бизнес эрхлэгчид тулгардаг санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх үүднээс зах зээлээс бага хүүтэй, үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй хугацаа ихтэй зээлийг жижиг, дунд үйлвэрлэгчидэд хүргэх 117 сая доллар.

Гуравдугаарт нь нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн доройтлыг арилгах зорилгоор малчдын бэлчээрлэх дадлыг сайжруулах, мөн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд шаардлагатай төлөвлөгөө, арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хөдөө аж үйлдвэрлэлийн паркийн менежменттэй холбоотой төр, хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг судлах зэрэг болно. Үүнд 137 сая доллар зарцуулна.

Энэхүү санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд урьд өмнө байгаагүй өндөр дүнтэй буюу нийт 78 сая долларын буцалтгүй тусламжийг зээлдэгч байгууллагуудаас олгохоор байна.

Түүнчлэн Уур амьсгалын ногоон сангаас авч байгаа 130 сая долларын 0 хувийн хүүтэй, 10 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх 40 жилийн эргэн төлөх нөхцөлтэй. Мөн Азийн хөгжлийн банкнаас авч буй зээл 270 сая доллар нь 2 хувийн хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх 25 жилийн эргэн төлөх нөхцөлтэй бөгөөд Европын хөрөнгө оруулалтын банкнаас авч буй зээл нь 150 сая доллар. Энэ нь тогтмол 2.92 хувийн хүүтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх 25 жилийн эргэн төлөх нөхцөлтэй. Нийт 550 сая ам.долларын зээлийн эх үүсвэртэй болно.

Тус санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг байгуулснаар Монгол Улс нь хөтөлбөрийн санхүүжилтийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд хөтөлбөрийн эх үүсвэрийг тухайн олон улсын байгууллагууд Монгол Улсад олгохоор хуваарилалт хийн хадгалж байгаа хэлбэр болно.

Түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Монгол Улс санхүүжилт хүсэх хууль зүйн үүрэг хүлээхгүй ба зээлийн гэрээ байгуулаагүй тохиолдолд хөтөлбөрийн хүрээнд үүссэн эх үүсвэрийг бүрэн цуцлах бүрэн эрхтэй.

Энэхүү санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай. Тиймээс Соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эдийн засгийн, хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайд гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд бүх яамдын саналыг авч тусгасан болно. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Казах хэлээ сур. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урья.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 7 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр уг хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд энэ хөтөлбөрийн хүрээнд аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг хөгжүүлэх, авто зам барих, төвлөрсөн дулаан хангамж, ус зайлуулах

хоолой, бохир усны хоолойг барихад зарцуулах хөрөнгө оруулалт хэр оновчтой болох, 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургах, уур амьсгал, тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, бүсчилсэн хөгжлийн үндэсний 6 бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасныг өөрчилж эрчимжсэн хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх зэрэг шаардлагатай төсөл, хөтөлбөрт зарцуулах боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбат зээлийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг зөв тооцоо, Баянхонгор аймагт ногоон хөгжил, бэлчээрийн доройтолтой тэмцэх төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх, цаашид сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээнд зарцуулдаг төслийн санхүүжилтийг багасгах, төсөл хэрэгжих аймаг, сумдыг ямар шалгуураар сонгосон талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхболд Төв аймгийн Зуунмод, Баянчандмань, Лүн, Угтаал зэрэг сумдад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн албан ёсны Монгол орчуулгыг сайжруулах шаардлагатай байгааг холбогдох байгууллагууд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны хомсдол зэрэг тулгамдсан асуудал ихтэй Өмнөговь аймгийг уг төсөл хөтөлбөрт ямар шалтгааны улмаас хамруулаагүй болох, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан Орхон-Онги төслийн хэрэгжилт ямар байгаа талаар ажлын хэсгийн гишүүдээс асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд төслийн санхүүжилтээр зохион байгуулдаг сургалт, семинар, судалгааны ажлыг багасгах, өөрсдийн нөөц бололцоогоороо дотооддоо хийж болох ажилд эрдэмтэд, судлаачдаа ашиглах, төсөл хөтөлбөр, гэрээ, зээлийн хэлэлцээрийн орчуулгыг зөв

хийх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шаардлагатай аймаг, сумдад төсөл хөтөлбөр хэрэгжихгүй байгааг анхаарах, цөлжилт, хөрсний доройтол бий болсон говь, тал хээрийн бүсийн аймаг, сумдад хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар хөтөлбөр зээлийн зарцуулалтыг, зориулалтыг цөлжиж байгаа бэлчээр, худаг ус ширгэсэн нөхцөл байдал хүндэрсэн аймаг, суманд хэрэгжүүлэх, бодитой судалгаа хийх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан уг төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан ногоон хувьсгалын хүрээнд хийгдэж байгаа ажлуудын нэг бөгөөд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болбол иргэдээ эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах том ажлын эхлэл болохыг онцлоод, энэхүү хөтөлбөр нь бүсчилсэн ногоон хөгжлийг хангах, бэлчээрийн доройтлыг бууруулах, агро бизнес эрхлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, хөдөө аж ахуйн паркуудыг байгуулах, урт хугацаатай, бага хүүтэй хөгжлийн зээлээс гадна 78 сая ам.долларын буцалтгүй тусламжийг авах боломжтой болно гэв.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга. Баагаагийн Баттөмөр гишүүнээр, Дамбын Батлут гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн. Энэ асуудлыг ер нь ингээд хариуцсан сайд нь байхгүй учраас хойшлууллаа.

Энэ аймгийг яаж сонгосон юм. Энэ Байнгын хороон дээр гарсан дүгнэлт нь ч гэсэн. Хууль санаачлагч байхгүй бол хойшлуулах дээтэй. Энэ аймгуудын сонголт өмнөхөөсөө бүүр ингээд сонин болгоод энэ ар, өврийн хаалгаар ийм ингэж зээл авч болохгүй.

Хойшлууллаа. Өнөөдөр эцэслэн батлах дэг ч алга байна. Өнөөдөр эцэслэн батлах ирц ч алга байна.

Дархлаажуулалтын тухай хууль, энэ шууд эцэслэн батлагдах, соёрхон батлах хууль.

16.32 цаг

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Эрүүл мэндийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заавал хийх дархлаажуулалтад сүрьеэ, халдварт саа, В вирус, гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаан бурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга орно гэж заасан байдаг.

Монгол Улс 1987 оноос дархлаажуулалтын товыг бий болгож баталсан. Дархлаажуулалтын үндэсний товыг шинэчлэн батлах тухай Монгол

Улсын Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоолыг улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Шинэ вакцины хөгжүүлэлт, хүн амын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан дархлаажуулалтын товллод шинэ вакцин нэвтрүүлэх практик зайлиггүй тулгарч тулгарч байгаа болно.

Тодруулбал хүн амын өвчлөл, нас баралтын томоохон шалтгаан болсон А вирус, гепатит, халдварт шар, пневмококк, уушгины хатгалгаа, хүний папиллома вирусийн умайн хүзүүний хавдар үүсгэгч хүний хөхөнцөр вирус, халдварын эсрэг вакцин нэвтрүүлэх зайлиггүй шаардлагатай байна.

Монгол Улсад 2011 оноос ер өмнө ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд А вируст гепатитын халдварын дэгдэлт бүртгэгдэж жилд, жил бүр 9000 гаруй хүүхэд шинээр өвчилж өсгөгчдийн 70 гаруй хувийг 9 хүртэлх насны хүүхэд эзэлж байсантай холбоотойгоор 2011 оноос улсын хэмжээнд тархвар судлалын заалтаар 1 нас 2 сартай, 2 настай хүүхдүүдийг дархлаажуулснаар шинэ тохиолдлын тоо 21.5 дахин буурсан үр дүнтэй байна.

Монгол Улсын хүн амын дундах өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох амьсгалын тогтолцооны өвчлөлийн дотор уушгины хатгалгаа өвчин 51.2 хувийг эзэлж, пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа өвчин 2 хүртэлх насны хүүхдүүдийн дундах өвчлөл нас баралтын гол шалтгаан болж байна.

Үүнтэй холбоотойгоор 2019, 2016 оноос Монгол Улсын Засгийн газар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран пневмококкийн эсрэг 13 цент вакциныг улсын хэмжээнд үе шаттай нэвтрүүлж эхэлсэн. Үүний үр дүнд уушгины хатгалгаа 26 хувь, хүнд хэлбэрийн хатгалгаа 42 хувь, маш хүнд хэлбэрийн хатгалгаа 46 хувиар тус тус буурсан байна.

Хүний папиллома вирус нь умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, эндэгдлийн гол шалтгаан болдог ба манай улсад уг вирусийн халдварын тархалт өндөр байна. Тухайлбал Зүүн өмнөд азийн орнуудад 100 000 хүн амд умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин 10.9, нас баралтын түвшин 4.1 байгаа бол манай улсад өвчлөл 100 000 хүн амд 23.5, нас баралт 10.2 байгаа нь бүс дотроо өвчний дарамт хамгийн өндөр үзүүлэлттэй орнуудын нэг болж байна.

Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдар эмэгтэйчүүд зонхилон тохиолдох хавдрын 2 дугаарт, нийт хорт хавдрын шинэ тохиолдлын 4 дүгээрт, нас баралтын 5 дугаарт эрэмбэлэгдэж байна.

А вирус гепатит, пневмококк хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтад хамрагдах, сэргийлэх тарилгын нэр төрөлд хамруулснаар дээрх өвчнүүдийн тохиолдол, нас баралтыг бууруулах эерэг үр дүнг бий болгоно гэж бид үзэж байгаа болно.

Эрхэм гишүүд ээ,

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэж, дэмжиж өгөхийг хүсэж байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт

оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч шинэ вакцины хөгжүүлэлт, хүн амын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан А вирус гепатит пневмококк, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтад хамрагдах, сэргийлэх тарилгын нэр төрөлд оруулснаар умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, халдварт өвчний тохиолдол, нас баралтыг бууруулна гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй бөгөөд А вируст гепатитын халдварын эсрэг вакцины дархлаажуулалт болон пневмококкийн эсрэг вакциныг хийснээрээ уг өвчнөөр өвчлөх, нас барах, бага насны хүүхдийн тоо буурч, гэр бүл, эмнэлэг, улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг нэвтрүүлснээр папиллома вирусийн халдварын улмаас үүсэх умайн хүзүүний хорт хавдрын урьдал эмгэг, умайн хүзүүний хорт хавдар болон бэлэг эрхтний хавдрын өвчлөл нас баралтын тоо буурах үр дүн гарна гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байриуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа дархлаажуулалтын талаарх мэдээлэл дутмаг байгаагаас иргэдийн хамрагдтал бага байдаг тул мэдээллийг хэрхэн хүртээмжтэй болгох талаар, умайн хүзүүний хавдар үүсгэгчээс урьдчилан сэргийлэх вакцинд эмэгтэйчүүдээс гадна гол вирус тээгч эрэгтэйчүүдийг хамруулж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен хэдэн төрлийн вакцинд хэр хэмжээний төсөв зарцуулж

байгаа талаар болон агаар дуслын замаар халдварын дэгдэлт нь ихсэж байгаа салхин цэцэг, кор зэрэг өвчний тархалтын талаарх патогенезын судалгаа байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хүний хөхөнцөр вирусийн дархлаажуулалтын вакциныг яаралтай товлотт вакцин болгосноор олон хүний амь нас, эрүүл мэндийг аврах боломжтой, төрөөс иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахад урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас гадна дархлаажуулалтад хамруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар санал хэллээ.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 88.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд суудалдаа сууя. Хэлэлцүүлэгтээ оръё. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Совдын Төгсдэлгэр, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Цэвэгмидийн Эрдэмбилэг, тус яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Дангаагийн Баярболд, Халдварт өвчин

судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны дарга Отгонбаярын Дашиагма.

Гишүүдийн анхаарлыг татах зорилгоор ч гэсэн ер нь төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 7 дугаар сарын 2-нд Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар Суурийн Лхагва, Цагаанлхамын Цэрэндолгор нарын хоёр дахь хүүхэд болон эхээс мэндэлжээ.

7 сарын 2-нд Улсын Их Хурлын гишүүн Батсуурь Норовын Жамц, Цэрэндоржийн Цэрмаа нарын бага хүүхэд болж эхээс мэндэлжээ.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Батболд Дамдины Сүхбаатар, Цэрэнгийн Янжин нарын отгон хүүхэд болж эхээс 6 дугаар сарын 24-нд мэндэлжээ. Ингээд төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүддээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон танд болон та бүхний гэр бүлийнхэнд нь, ээж Цэрэнгийн Янжинд, Суурийн Лхагва, Цагаанлхамын Цэрэндолгор нарт, манай Мөнхбаатар даргын аав, ээж нарт бас мэндчилгээ дэвшүүлж Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо асуулт байхгүй биз дээ. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байгаад бас үнэхээр талархалтай байгаа. Юунд талархаад байгаа юм бэ гэвэл бид өсвөр үеийнхнийгээ, ирээдүй хойч хүүхдүүдээ, тэр дундаа эмэгтэйчүүдээ халдварт

өвчнөөс сэргийлэх бас томоохон боломж нээгдэж байгаа. Өчигдөр бас Байнгын хорооны хуралдаанаараа энэ асуудлыг хэлэлцэгдэх явцад бас гишүүд ч гэсэн бас дэмжиж байгаагаа илэрхийлж байсан.

Өөрөөр хэлэх умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт буюу вакциныг хийх, товлолт вакцинд оруулах, албан вакцинд оруулах энэ зүйл, заалт орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид нар ирээдүй хүүхэд залуучуудаа, охидууд аа умайн хүзүүний хавдраас сэргийлэх бүрэн боломж үүсэж байгаа юм. Папиллома вирус буюу энэ умайн хүзүүний хавдрыг үүсгэж байгаа энэ вирусийн халдвар сүүлийн жилүүдэд бас улаан хоолойн хавдар үүсгэх гэж байгаа гэдэг ийм тоон мэдээллийг бас Эрүүл мэндийн яамныхан маань өгч байна.

Тэгэхлээр энэ бүхнээс урьдчилан сэргийлэх зайлиггүй шаардлага байгаа. Бидэнд байгаа мэдээллээр бэлгийн замын халдвараар дамжих халдварын тоо нэмэгдсэн, тэр дундаа өсвөр үеийнхний жирэмслэлт, бэлгийн ариун цэвэр хангагдахгүй байгаа гэдэг ийм мэдээлэл байгаа. Яг энэ дээр би бас тоон мэдээллийг өгч, олон нийтийг сэрэмжлүүлэх, мэдрүүлэх энэ дархлаажуулалтад хамрагдах тэр сэдлийг нь өгөх үүднээс тоон мэдээллийг өгөөч гэдэг ийм хүсэлт байна. Өөрөөр хэлэх юм бол Эрүүл мэндийн яаман дээр умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл ямар хэмжээнд байгаа юм, тэр дундаа эмэгтэйчүүдэд, эрчүүдэд ямар өвчлөл байна тоон мэдээлэл өгөөч. Нөгөөтээгүүр дархлаажуулалт буюу вакцины эсрэг ийм үйл ажиллагаа бас ихээр явдаг гэдэг ийм мэдээллийг бас Эрүүл мэндийн яамныхан маань өгсөн.

Тэгэхлээр бид өөрөөр хэлэх юм бол дархлаажуулалт, вакцинтай холбоотой зөв, эерэг мэдээллийг олон нийтэд өгөх үйл ажиллагаа бас дутагдалтай байна гэдэг ийм дүгнэлтийг хийж болохоор байгаа юм. Тэгэхээр энэ талаар бас мэдээллийг өгөөч.

Бидэнд байгаа мэдээллээр Монгол Улсын хэмжээнд өвчлөлийн 100 000 хүн ам тутамд 23.5, нас баралтад 10.2 хувь байгаа нь энэ дотроос өвчний папиллома вирусээр халдварлаж байгаа халдвар бас өндөр байна гэж харж байгаа. Зонхилсон тохиолдох хавдрын хоёрдугаарт нийт хорт хавдрын шинэ тохиолдлын 4 дүгээрт, нас баралтын 5 дугаарт эрэмбэлэгдэж байна гэдэг ийм зүрх өвтгөсөн тоо байгаа.

Тэгэхлээр яг энэ тоо баримтыг бидэнд өгөөч. Тэгээд бас би эрчүүдийгээ, эрэгтэй гишүүдийгээ энэ асуудлуудаас онцгойлон анхаарч энэ хуулийг яаралтай батлахад бас саналаа өгөөрэй гэдэг ийм хүсэлтийг хэлэх гэж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол бид нар энэ хуулийг яаралтай баталснаас тодорхой хэмжээний төсвийг батлах, суулгах, нөгөө талаар товлолт вакцины жагсаалтад оруулах ийм шаардлага үүсэж байгаа учраас гишүүдийг бас идэвхтэйгээр саналаа өгөөрэй гэж уриалгыг хэлье. Асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулна.

С.Чинзориг: Би хариулъя. Тэгээд манай яамны дарга нар нэмэлт бас тайлбар хэлбэл хэлэх байсан юм. Энэ умайн хүзүүний хорт хавдрын гол үүсгэгч болоод байгаа энэ папилломагийн вирусийн вакциныг Дархлаажуулалтынхаа хуульд өөрчлөлт оруулж товлолт вакцин вакцинжуулалтад оруулах гээд байгаа юм. Энэ хууль ингээд дэмжигдээд батлагдвал дараагаар нь бид хуулийнхаа дагуу Засгийн газар товлолыг нь тогтоох, хэдэн наснаас тарих вэ, ямар тунгаар тарих вэ, хэдэн удаа давтамжтайгаар тарих вэ эд нар ингээд энэ хуулийнхаа дагуу Засгийн газар шийдвэр гарах юм байна лээ.

Манайд бол бас нөхцөл байдал бол бас амаргүй л байгаа юм байна лээ. Би

түрүүн сая илтгэлдээ бас танилцуулсан. Дэлхийн энэ умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлөөр манайх дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна, 2 дахин. Нас баралтын түвшин дэлхийн дунджаас 1.5 дахин өндөр байна гэсэн ийм статистик мэдээ бол байх юм. Сүүлийн 4, 5 жилийн судалгааг бид наравч үзсэн. Жил тутам 318-480 шинэ тохиолдол энэ умайн хүзүүн хорт хавдрын тохиолдлууд бүртгэгдэж байна гэсэн ийм судалгаа байгаа юм.

Харамсалтай дүн мэдээ нь жил тутам 146-190 хүн энэ умайн хүзүүний хорт хавдрын улмаас нас барсан байна гэсэн ийм бас статистик байгаа. Тэгэхээр энэ бол бас иргэдийн дунд маш өндөр бас байгаа. Ялангуяа энэ хорт хавдрын өвчлөл дотроо бас умайн хүзүүн хорт хавдар 4.6 хувийг одоо эзэлж байгаа бас ийм өндөр үзүүлэлттэй бол байгаа юм.

Тийм учраас бол энийг Дархлаажуулалтын тухай хуульд оруулж, товлолт вакцинжуулалтад оруулах, ингэснээрээ умайн хүзүүн хорт хавдраас бас урьдчилан сэргийлэх ийм нөхцөл боломж бол бүрдэнэ гэж үзэж байгаа. Иргэдийн дунд бол вакцинтай ер нь бүх ямар ч төрлийн л вакцинтай холбоотой мэдээлэл, зөв сурталчилгааг өгөх ёстой асуудал дээр бид нэлээн сайн анхаарах хэрэгтэй.

Ялангуяа бид энэ хуулийн дараагаар Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн асуудал бас яригдана. Энэ хууль дээр ч гэсэн бидний гол ярих юм энэнтэй холбоотой асуудал. Ялангуяа энэ иргэдийн эрүүл мэндийн боловсролыг бас дээшлүүлэх чиглэлийн асуудлаар бид нар нэлээн бас эргэлт бас гарах зайлиггүй шаардлагатай гэж үзэж байгаа.

Тийм учраас нийгмийн дунд байдаг энэ вакцинтай холбоотой эерэг, сөрөг янз янзын л ойлголттой байдаг. Тийм учраас эерэг ийм талын сурталчилгааг нэлээн сайн хийж, вакцинжуулалтад нэлээн өргөн хамруулах ийм арга хэмжээ авах ёстой гэж үзэж байгаа.

Улс орнууд бол вакцин хийхэд энэ нас насны тухайд янз янз л байдаг юм байна лээ. Америкийн Нэгдсэн Улс гэхэд 9 наснаас, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага гэхэд 11 наснаас охидыг энэ вакцинд хамруулахыг бол зөвлөж байгаа юм. Манайх бол одоогийн ямар ч байсан судалгаагаар бол 19 онд энэ судалгаа хийгдээд нэлээн тийм дүгнэлт гарсан гэж манайхан мэдээлэл өгдөг. Тэгэхээр манайд 11 настайгаас нь энэ товлолт вакцинд хамруулж, хамруулах нь зүйтэй гэсэн ийм бас тооцоо судалгаатай энэ удаагийн хуулийг оруулж байна.

Тэгээд манай ажлын хэсгийнхэн нэмэлт тайлбар байвал бас нэмж тайлбар өгч болох юм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

С.Төгсдэлгэр: Төгсдэлгэр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Вакцины хувьд бол маш үр дүнтэй эдийн засгийн хувьд үр ашигтай гэдэг нь дэлхий нийтэд батлагдчихсан ийм нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ байгаа. Манай улс бол 2000 оноос энэ халдварт саа өвчнийг вакцины тусламжтай бүрэн устгасан байгаа. Тэрнээс гадна сахуу, хөхүүл, ханиад, татран гэх мэт өндөр эндэгдлийн түвшин өндөртэй энэ өвлөлүүдийн тархалтыг бүрэн зогсоосон сүүлийн 20-иод жилд. Вакцин нэвтрүүлэхээс өмнө гахайн хавдар, гахайн хавдрын өвчлөлийн түвшин вакцин нэвтрүүлсний дараах одоогийн байдалтай ингээд харьцуулахад 30 дахин буурсан. Тэгэхээр гахайн хавдар гэдэг бол өөрөө үргүйдэлд хүргэдэг асар их алсдаа хүндрэл сөрөг үр нөлөөтэй өвчнийг ингэж их бууруулсан нь яах аргагүй вакцины ач тус байгаа.

Эдийн засгийн хувьд үр ашгийг нь харуулах цорын ганц үзүүлэлт гэх юм бол улаан бурхан өвчний өвчлөлийг бид нар

вакцин нэвтрүүлснээр 1000 гаруй дахин бууруулсан. Гэтэл 2016 онд 15, 16 онд гарсан томоохон дэгдэлтийн үед бид нар энэ улаан бурхан өвчний дэгдэлтийг таслан зогсоохын төлөөнөөс 5 тэрбум төгрөг зөвхөн нэмэлт вакцинжуулалтад зарцуулсан.

Тэгэхээр энэ вакцины арга хэмжээ бид нарт жилдээ хэчнээн их эдийн засгийн хувьд үр ашигтай, хэмнэлттэй болох нь энэ ганц энэ тооноос харагдах байх. Түүнээс гадна гепатит вакциныг бид нар 2011 оноос нэвтрүүлснээсээ хойш бол өнөөдрийн байдлаар өвчлөлийг 80 гаруй хувиар ингээд бууруулаад энэний улмаас учирч байгаа хохирлыг жилдээ хамгийн багаар тооцоход бараг 3 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаад ингээд явж байгаа. Энэ гепатит HPV вакциныг нэвтрүүлэхэд бид нарт нэмэлтээр 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт жилдээ шаардлагатай. Тэгэхээр энэ мөнгөн дүнг бид нарын вакцины тусламжтайгаар өвчлөлөөс, нас баралтаас сэргийлж хэмнэж байгаа мөнгөн дүнтэй харьцуулахад асар их үр ашигтай ийм арга хэмжээ байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу та. Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Би бас зарим тоо баримт хэлье. 2021 оны байдлаар манай улсад өсвөр насны охидын жирэмслэлт 4.8 хувьтай байсан байна. Энэ нь жилдээ 4000 орчим өсвөр насны хүүхэд жирэмсэлж байна гэдэг ийм тоо юм байна. Нийтдээ жилд 12043 эмэгтэй үр хөндүүлэх мэс засал хийлгэдэг бол үүний 4.7 хувийг нь өсвөр насны хүүхдүүд эзэлж байна гэдэг ийм тоон мэдээлэл.

Тэгэхлээр би яагаад тоо хэлээд байна вэ гэвэл өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн боловсрол, бэлгийн ариун цэвэр, бэлгийн хүмүүжлийг олгох энэ сургалт бас хангалтгүй байгаа. Энэ дээр Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа өсвөрийн хүүхдүүдийн

кабинетаа хангалттай ажиллуулаач гэдэг зүйлийг яриад байгаа юм.

Сүүлийн үед папиллома вирусээр халдварласан улаан хоолойн хорт хавдрын үзүүлэлт, тоо нэмэгдэж байна гэдэг бол яг энэ вакциныг бид нэн даруй хийхгүй бол болохгүй нь. Урьдчилсан сэргийлэлт хийгдэх шаардлагатай байна гэдэг бас дүн мэдээ гэж би харж байна.

Тэгэхлээр энэ вакцинд хүүхдүүдээр нь хэдэн наснаас хамруулах төлөвлөлттэй байгаа юм. Эрэгтэй, эмэгтэй хүйсийн ямар нэгэн ялгаа байгаа юу. Папиллома вирусээр халдварласан улаан хоолойн хорт хавдрын тоон мэдээ бидэнд байна уу, үгүй юу гэдэг дээр.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тодруулгад хэн хариулах вэ. Ажлын хэсэг 81 дүгээр микрофон. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофон өгөөрэй.

С.Төгсдэлгэр: Энэ HPV вакцины тухайд бол бид нар 11 настай өсвөр үеийн хүүхдүүдийг хамруулахаар төлөвлөж байгаа. Хүйсийн ямар нэгэн ялгаагүй охидууд, хөвгүүд бүгдийг нь хамруулахаар ингэж төлөвлөж байгаа. HPV вирусийн халдварын хувьд бол залгиурын хорт хавдрыг үүсгэх ийм эрсдэлтэй. Тэгэхдээ яг зөвхөн HPV-ээс гадна энэ залгиурын хорт хавдрыг үүсгэдэг олон хүчин зүйл байдаг. Яг манай улсад хэдэн хувийг нь энэ HPV-ийн шалтгаанд байна вэ гэдгийг тогтоосон судалгаа хараахан байхгүй байна.

Тэгэхдээ энэ бусад улс орнуудад судлагдсан ёсоор энэ вирус залгиурын хорт хавдар үүсгэх эрсдэлт хүчин зүйл болдог нь тогтоогдсон учраас манайд ч гэсэн энэ вакциныг хийснээрээ зөвхөн умайн хүзүүн халдвар төдийгүй залгиурын хорт хавдраас бас сэргийлэх боломжтой.

Л.Мөнхбаатар: Дамбын Батлут гишүүн асуултаа асууя. Байхгүй байна. Одоо Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Хуулийн төслийн хувьд тусгайлсан саналгүй, дэмжиж байгаа. Тэгэхдээ хуульд өөрчлөлт орж байгаатай холбоотой заавал сануулах хэлэх ёстой нэг асуудал байна. Энэ дархлаажуулалтын ач холбогдол, нийгмийн эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийн хүн амд ухуулан сурталчлах ажлыг эрчимжүүлэх талаар юм. Интернэт, нийгмийн сүлжээний боломж өргөжихийн хэрээр вакциныг эсэргүүцэгч бүлгүүд мөн идэвхжиж байна. Ил далд олон групп байдаг, хүн ам ч дархлаажуулалтын үр ашгийг мартаж эхэлж байна. Хуулийн энэ танилцуулгад дурдсан байна л даа 2011 оноос өмнө жил бүүр 9000 гаруй хүүхэд бидний ярьж заншсанаар бохирын гепатитаар өвчилж байсан. 22 онд ердөө 14 хүүхэд өвчилсөн гэсэн ийм бүртгэл байна. Сүүлийн 10 жилд өвчлөл 99 дахин буурч. Тэгэхлээр энэ нийгмийн эрүүл мэндийн вакцинжуулалтаас өөр ийм үр дүнтэй арга одоогоор нийгмийн эрүүл мэндийн салбарт олдоогүй байгаа.

Тийм учраас бид энийг бүүр онцгойлон санаж байх ёстой. Тэгэхдээ эрсдэл арилаагүй. Гэр хорооллын айлуудын нүхэн жорлонгийн асуудал шийдэгдэх болоогүй байна. Өнөөдрийн энэ үер устай холбоотой, хөрсний бохирдолд, баас, шээс үүгээр дамжиж энэ гепатит А буюу бохирын шар тархах эрсдэл асар их өндөр болж байна. Хөрсний бохирдолд 2, 3 жилээр үргэлжилдэг, агаарын бохирдол бол салхи үлээгээд л байхгүй болчихдог.

Тийм учраас хөрсний бохирдолт гэдэг бол өөрөө онцгой анхаарах ёстой нэг асуудал юм. Тийм учраас бид өнөөдөр Монголчууд бид энэ нүхэн жорлонгоосоо салж чадаагүй байгаа нөхцөлд гепатит А-гийн талаар вакцинжуулалтын асуудлыг ярьсаар л байх хэрэгтэй.

Иймд дархлаажуулалтын ач холбогдлыг мартуулахгүй, хүн амд эергээр ойлгуулах, дархлаажуулалт нэвтрээгүй үед өвчлөл ямар байсныг хэдэн хүүхэд нас барж байсныг сануулж

байх ёстой. Энэ далайцтай тоо баримттай, итгэл үнэмшил төрүүлэх түвшинд энэ ойлгуулах ажлыг, нөлөөлөх ажлыг сайн хийцгээе. Одоо бас ийм жишээ хэлмээр байгаа юм 90 оны шилжилтийн үед энэ дархлаажуулалтын хамралт суларсны балгийг 2015 оны улаан бурхны дэгдэлт харуулсан. 90-ээд оныхон яг эд ээж нар болж байгаа. Тэгээд эхийн сүүгээр авах ёстой дархлаагаа авч чадаагүй нярай хүүхдүүд олноор өвчин авч, нас барж байсан.

Тэгэхлээр энэ өвчлөл гарахгүй байна гэдэг нь өөрөө алга болсон гэсэн үг биш, юу ч хийхгүй байгаа гэсэн үг бүүр биш. Олон зуун нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд дархлаажуулалтын нэргүй хөдөлмөрийн үр дүнд гэдгийг нийтээрээ ойлгох ёстой. Энэ өрхийн эмнэлгүүдээр дамжуулан бид энэ нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор вакцинжуулалтыг хийж байна. Энэ өөрөө асар их нөлөө үзүүлж байгаа. Олон олон өвчнийг сэргийлэхэд тус дэм болж байгааг ерөөсөө мартаж болохгүй.

Тийм учраас энэ нийгмийн эрүүлжүүлэх вакцинжуулалтын ажил хийж байгаа энэ нэр нь дурдагддаггүй энэ улсуудын бас ажлыг үнэлж байя. Одоо бас сахуу, татран, хөхүүл ханиад, улаан бурхан гээд зөвхөн амьсгалсныхаа төлөө амьсгалын замаар халддаг энэ өвчин туссан нь бараг бүгд нас бардаг ийм өвчнүүд зөвхөн дархлаажуулалтын хүчээр л гарахгүй байгааг бид мартаж болохгүй. Энэ бол анагаах ухааны ололт юм.

Тэгээд бас төгсгөлд нь би бас Эрүүл мэндийн яамныханд бас ийм юм хэлмээр байгаа юм. Энэ мэдээлэл, сургалт, сурталчилгаагаа идэвхжүүлэх хэрэгтэй байна. Та бүгдийн page хуудсаар нэг өдөр баахан гар угаах нь чухал, маскаа зүүх гээд л ярьж байснаа маргааш нь гэнэтхэн л эрүүл мэндийн салбарын ажилчдадаа шагнаад л урамшуулаад л тэгээд page-ээр чинь ийм олон төрлийн мэдээлэл явахлаар олон нийт дагахгүй байна дагахгүй байна. Та бүхэн ажигла л

даа энэ хувийн хэвилийнхэн, энэ худалдааны байгууллагууд нэг бүтээгдэхүүндээ зориулаад нэг л page гаргаад түүгээрээ дамжуулаад олон нийтэд нөлөөлөх ажил хийгээд байна шүү дээ.

Тийм учраас Эрүүл мэндийн яам энэ хэвлэл мэдээллээ нэг урсгалтай болгоод түүгээрээ олон нийтэд нөлөөлөх үйл ажиллагааг баяр ёслолтойгоо битгий хольж хутгаарай. Энийгээ бүүр онцгойлон анхаарч PR-ын зөвлөхтэй болоо, олон нийтэд мэдээллийг оновчтой болгох ажлыг эрчимжүүл гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн үг хэллээ. Төслийг дэмжиж үг хэллээ. Одоо Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Дархлаажуулалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гаргаж үзэж байгаа юм. Ер нь одоо хүн төрөлхтөн энэ халдварт өвчин, хавдар, бас зонхилон тохиолдоод байгаа өвчнүүдийн вирусийг дарангуйлах хэлбэрээр л энэ дархлаажуулалт бий болгох л үйл явцыг л вакцинаар дамжуулж л хийгээд л байгаа. Тодорхой эрсдэлийг бууруулж, зарим тохиолдолд бараг гаралтыг байхгүй болгож байгаа ийм л үйл явц л харагддаг л даа. Тэгэхээр зэрэг энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн гэдэг юм уу, зөвшөөрсөн гэдэг юм уу вакцинуудаас Монгол ер нь хийдэггүй гэдэг юм уу, хэрэглэдэггүй вакцин гэж байна уу. Энэ дээр тодруулга авмаар байна.

Хоёрдугаарт биднүүс чинь энэ хатгалтын тоог бууруулъя гээд Тавт вакцин гээд баахан ярьцаагаад товлолынхоо вакцин руу оруулж ирээд ингээд яваад байгаа улс. Одоо энэ шинээр нэмэгдэж байгаа вакцинууд чинь бас яг үүнтэйгээ адилхан хосолмол үйлчилгээтэй гэдэг юм уу тийм вакцин байгаа юу. Энэ талаар ер нь биднүүс ямархуу байдлаар энэ судалж, энэ арга

тактикийг энэ эрүүл мэндийн салбартаа хэрэглэдэг юм бэ гэдэг асуудал байна.

Гурав дахь зүйл, манай эрүүл мэндийн байгууллагын эрдэмтэн, судлаачид энэ дархлаажуулалт хорттой гэдэг юмыг нийгмийн сэтгэл зүйд гаргаж яриад болгоомжлол үүсгээд байдаг. Бүүр тов тодорхой нэр устай улсууд бий шүү дээ. Үгүй ер нь үүндээ эрүүл мэндийн байгууллага ер нь юу гэж ханддаг юм бэ. Өөрсдөө учир шалтгааныг нь мэдсээр байж энэ нийгмийн сэтгэл зүйг ингэж янз бүрийн байдалд оруулаад байгаа улсууд дээрээ ер нь ямар арга хэмжээ авдаг юм. Энэ хуулийг дагуулж энэ нийгмийн сэтгэл зүйг эвдээд байгаа гэдэг юм уу, болгоомжлол үүсгээд байгаа улсуудад тооцох хариуцлагын ямар механизм заалт байгаа юм бэ. Ийм хэдэн зүйл дээр тодорхой хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад ажлын хэсгээс хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

С.Төгсдэлгэр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ манай улсад заавал хийх дархлаажуулалтад хамрагдаж байгаа вакцинууд бүгд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөмж болгож байгаа вакцинууд байдаг. Тэгээд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөмж болгож байгаа төдийгүй хуульдаа бид нар 2010 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр НҮБ-ын байгууллагаар дамжуулж энэ баталгаатай вакциныг, чанарын баталгаатай вакциныг хүүхдүүдэд хийж байгаа.

Харин тэр юуны Тавт вакцин, гурав дахь вакцины тухайд гэвэл бид нар энийг нэвтрүүлснээр жилд хийгдэх хатгалтын тоог асар бууруулж байгаа. Зөвхөн энэ Тавт вакциныг нэвтрүүлснээр бид нар жилдээ 450 000 хатгалт хийхээс сэргийлж чадаж байгаа. Тэгэхээр одоо бид нар товлот вакцинаар бол 6 төрлийн вакцинаар 10 төрлийн өвчнөөс сэргийлэх ийм боломжтой болоод жилдээ 450 000

хатгалтыг бууруулж чадсан ийм үзүүлэлттэй байгаа. Одоогоор шинээр нэвтрүүлэхээр орж ирж байгаа гепатит А, HPV болон пневмококкийн эсрэг вакцин бол яг дан ганц ийм вакцин байгаа. Өөрөөр хэлбэл олон өвчнөөс хавсарсан тийм вакцин биш.

Вакцины эсрэг буруу сурталчилгаа явуулж байгаа асуудал дээр бол бид нар бас тодорхой хэмжээгээр хариуцлагын хууль, хяналтын байгууллагуудад энэ вакцины эсрэг буруу сурталчилгаа явуулж байгаа хүмүүсийг мэдээлэх замаар таслан зогсоох, сэргийлэх арга хэмжээ авч байгаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн асуултаа асууя. Гишүүд танхимд орж ирээрэй. Санал хураалт явагдана.

М.Оюунчимэг:

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжихээр барах уу энэ дэндүү хоцрогдож орж ирж байна. Одоо энэ хөрсний бохирдлын тухай бид өнөөдөр ярина гэдэг угаасаа утгагүй асуудал. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд хурч байна, хөрсний бохирдлоос үүдэлтэй хорт хавдрын өвчлөл, хүүхдийн энэ нас баралт маш өндөр түвшинд хүрээд байна шүү дээ. Тэгэхээр А гепатит вирусийг товлот вакцины тоонд оруулаагүй өнөөдөр болтол явж ирсний шалтгааныг би асуумаар байх юм. Яагаад ингэж удаад байгаа юм бэ. Бид маш олон удаа та нарыг оруулаад ирээрэй гээд хэлж байсан. Одоо энэ Чинзориг сайд л оруулж ирж байна л даа.

Дээрээс нь умайн хүзүү хорт хавдрын эсрэг энэ хүний папиллома вирусийг бүр 2011 онд тухайн үеийн эрүүл мэндийн дэд сайд байсан Цолмон сайд яаралтай энийг хийхгүй бол хорт хавдрын өвчлөлөөр, умайн хүзүү, хорт хавдрын өвчлөлөөр бид дэлхийн хэмжээнд бараг нэр нүүрээ барахад хүрэх магадлал өндөр байна гээд өөрийнхөө 2 охин дээр хүртэл туршиж байсан.

Гэвч нийгэмд сөрөг үзэгдэл болгож хувиргаад, улс төржүүлээд зогсоочихсон. Хэрвээ 2011 онд энэ умайн хүзүү хорт хавдрын эсрэг вакциныг бид хийгээд хэрэгжүүлсэн бол ингээж дэлхийн дунджаар өвчлөлөөрөө 2 дахин, нас баралтаараа 1.5 дахин хэмжээнд хүрлээ гээд өнөөдөр яриад сууж байхгүй л дээ. Тэгэхээр саяын нөгөө Батжаргал гишүүний хэлдэг шиг энд нээрээ л бид ийм энэ эсэргүү үйл ажиллагаа шүү дээ. Хүний эрүүл мэндийн эсрэг ийм эсэргүү үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүст хариуцлага тооцох ёстой. Тэгээд өнөөдөр энэ орж ирж байна. Энэ өөрөө маш чухал гээд дэлхийд хүлээн зөвшөөрөгдчихсон. Тэгээд энэ умайн хүзүүний эсрэг хорт хавдрын эсрэг А гепатит вирусийн энийг аль эртнээс хийх ёстой гээд байхад өнөөдрийг хүртэл ингээж явж ирж байгаа байхгүй юу. Сайн дураараа хүмүүс их хийлгээд байдаг.

Гэхдээ энэ өөрөө товлолт вакцины тоонд нь ороогүй ингээд явж байгаад би Эрүүл мэндийн яамныхнаас асуумаар байна. Яагаад өнөөдрийг хүртэл ингээж удаж байгаа юм бэ. Заавал ингээж нас баралтын тоо, өвчлөлөөрөө дэлхийд дээгүүрт оруулж энийг ингээж гайхагдаж байж Монголынхоо нэр хүндийг унагааж байж энэ асуудал ингээж шийдэгдэх ёстой байсан юм уу. Энэ бол дэндүү хариуцлагагүй асуудал. Одоо та нар хар өнөөдөр энэ борооноос үүдэлтэй энэ урсаж байгаа ус, тэр бохирьг хар, хөрсний бохирдлыг хар тэр чигээрээ ёстой нөгөө А гепатит вирусийг үүсгэх юу урсаж байна шүү дээ. Тэгэхэд бид өнөөдөр энэ вакциныг товлолт вакцины тоонд оруулах, оруулахгүй тухай асуудлаа оруулж ирээд ярьж байна л даа. Бүүр дэндүү хоцрогдож байна, дэндүү хоцорч байна, дэндүү хариуцлагагүй ажиллаж байна ийм зүйл дээр.

Тэгээд одоо энийг бид нээрээ цаг алдалгүй маш хурдан товлолт вакцины тоонд энэ дээрх вакцинуудыг оруулах шаардлагатай байна. Энэ өөрөө хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдгийг Дэлхийн эрүүл

мэндийн байгууллагаас болоод олон улс орон туршаад баталчихсан.

Гэтэл бид нар өнөөдөр энэ ялангуяа умайн хүзүүн хорт хавдраар өнөөдөр үнэхээр аймигийн түвшинд хүрчихсэн байна шүү дээ. Энэ тоон үзүүлэлтээ ч та нар өнөөдөр хараад үз дээ. Дэлхийн дунджаар өвчлөлөөрөө 2 дахин өндөр, нас баралтаар 1.5 дахин өндөр гэдэг үзүүлэлтийг энд яриад сууж байна гэдэг үнэхээр харамсмаар байна л даа.

Тэгээд өнөөдөр би Улсын Их Хурлын гишүүд энэ асуудлыг яаралтай батлаад, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд тэгээд намар энэ асуудлыг эцсийн энэ хэлэлцүүлэгт байна гэдэг чинь бас л цаг хугацаа алдах гээд байна л даа. Ямар ч байсан хууль, эрх зүйн хувьд нь энийгээ хурдан шийдээд явчих нь чухал байгаа учраас дэмжиж байна. Тэгээд гишүүд маань энд маш хариуцлагатай хандахыг бас уриалж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

С.Төгсдэлгэр: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Гепатит А-ийн вакциныг бол бид нар 2011 оноос нэвтрүүлчихсэн байгаа. Товлолт хууль, эрх зүйн хувьд өнөөдөр оруулж ирэхээр орж ирж байгаа.

Ер нь бол вакциныг аливаа вакциныг шинээр нэвтрүүлэхдээ тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэхээс гадна санхүүгийн тогтвортой байдлыг нь хангах зайлшгүй шаардлагатай байдаг. Тийм учраас бид нар гепатит А вакциныг бол 2011 оноос өвчлөл ихтэй газруудад газар зүйн заалтаар хийх маягаар эхлээд өргөжүүлсээр байгаад 2012 онд гэхэд нийт хүүхдүүдийнхээ 98 хувийг хамруулсан. Тэрнээс хойш энэ гепатит А вакцин хэдийгээр яг эрх зүйн хувьд хуульд ороогүй ч гэсэн бүх хүүхдүүдэд хийгдэж байгаа ийм вакцин байгаа.

Тэгээд HPV вирусийн тухайд гэвэл 2011 онд анх Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд энэ вакциныг анх нэвтрүүлэх ажил эхэлсэн. Тэгээд тухайн үедээ энэ вакцин нь асар үнэтэй 1 хүн тун нь 25 орчим долларын үнэтэй, тэгээд тухайн үеийн нотолгоогоор бол 3 удаагийн дархлаажих 3 тун хийж байж бүрэн хамгаална гэсэн нотолгоотой байсан. Энэ тохиолдолд манай улсын хувьд эдийн засгийн хувьд нэвтрүүлэхэд жоохон хүндрэлтэй байсан. Өнөөдрийн байдлаар бол үнэ нь 4.1 хүн тун нь 4.5 орчим доллар болж 5 гаруй дахин буурснаас гадна сүүлийн үеийн судалгаагаар 1 тун хангалттай хамгаалах чадвартай гэдэг нь нотлогдсон учраас өртгийн хувьд 15 дахин буурсан. Энэ нь бид нарт өнөөдөр HPV вакциныг товллод нэвтрүүлэх боломжийг олгож байгаа.

Тэгэхээр вакциныг нэвтрүүлэхдээ давхар нөгөө санхүүгийн тогтвортой байдлыг нь хангах чухал байдаг учраас HPV вакцин тархвар зүйн сайн дурын дархлаажуулалтаар хийгдэж байгаад одоогоос товллод орж байгаа юм тодруулах юм уу.

Л.Мөнхбаатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч маань ингээд л яаж ийгээд л хариу тайлбар өгөх нь л чухал байгаад байна л даа. Сайн дураараа хийж байна. Тэгээд хууль, эрх зүйн акт байхгүй учраас сайн дураараа хийж байсан гэж би ойлголоо тээ. Яагаад энийг тэгээд товллод болоод яг хууль, эрх зүйн хувьд нь шийдчихээгүй юм бэ гэдгийг л асуугаад байна шүү дээ. Энэ чинь өөрөө чухал байгаа байхгүй юу. Тэгээд та нарын хариулт нь зүгээр л юмыг хариу өгчихөд боллоо гэсэн зүйлтэй. Ажлаа сайн хий л дээ. Битгий ингээд өөрсдийнхөө удаашралтай, удаан ажиллаж байгаа, хариуцлагагүй ажиллаж байгаагаа хэдэн статистик юм уу тоо баримт урдаас хэлчхээд суугаад байвал наад ажил чинь явахгүй байна шүү дээ. Бид нар энэ

өнгөрсөн 2, 3 жил зөндөө хэлсэн та нарт. Одоо л орж ирж байна шүү дээ.

Тэгээд энэ дээрээ төсөв нь нэмэгдэхгүй юу. Одоо төсвийн тодотгол хийхэд энэ асуудлыг хийх хэрэгтэй болох уу, эсвэл 24 оны төсвийн асуудал дээр энийг тусгаад ороод ирчихсэн байгаа юм уу. Салбарын сайдаас би төсөвтэй холбоотой товчхон мэдээлэл авахыг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад Чинзориг сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Тийм, 3 вакциныг товллод вакцинд хамруулах асуудал оруулж ирж байгаа юм. Халдварт шар, уушгины хатгалгаа энэ 2 вакцин бол манайд одоо бол хэрэгжээд хийгдээд явж байгаа сайн дурын үндэс. Гэхдээ хамрагдалт бол өндөр юм байна лээ. 90 орчим хувийн хамрагдалттай байдаг гэсэн ийм вакцин байгаа юм.

Төсөв бол нэмэгдэх юм байхгүй. Энэ жилийнхээ батлагдсан төсөвтөө бол тусгаад багтаагаад хийчих боломжтой. Энэ жилийн төсөвт энэ 3 вакциныг вакцинжуулахтай холбоотойгоор зардал гээд 1.5 тэрбум төгрөг улсын төсөвт, сайдын багцад тусчихсан. Тийм учраас хөрөнгө санхүүгийн хувьд бол нэмэлт эх үүсвэр шаардах асуудал байхгүй. Анхны хэлэлцүүлгийг яаралтай Байнгын хороо хийж өгвөл анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн ийм горимын санал гаргаад ингээд яаралтай энэ чуулган завсарлахаас өмнө батлаад өгчихвөл сайн байна гэсэн ийм бас саналыг Байнгын хороон дээр хэлсэн юм. Гишүүд бас дэмжих болов уу гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Даваасүрэн гишүүн үг хэлье. Одоо санал хураалтын явагдана гишүүд танхимд цуглаарай. Даваасүрэн гишүүний микрофоныг өгөөрэй. Даваасүрэн гишүүн

та картаа уншуулчих ахиад. Тэг тэг дээ. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тийм мэдээж хэрэг ингээд вакцин үр дүнгээ өгч байгаа өвчнүүд байна байна. Байлгүй яах юм. Тэгэхдээ та нар вакциныг хэрэглэхдээ тухайн улс орондоо бүртгэгдсэн олон улсын эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн вакциныг хэрэглэх хэрэгтэй. Хуучин тэр харвони гэж орж ирээд бид нар туршигдсан шүү. Тэр шиг юм хийж болохгүй. Тэр вакциныг турисаны төлөө хэчнээн элэгний өөхлөлттэй улсууд нас барсан гэж бодож байна та нар. 65 наснаас дээш дархлаа султай хэчнээн хүн үхсэн гэж бодож байна. Ингээд вакциныг турших гэдэг яагаад гэвэл Америкт энэ хөгжингүй орнуудад зөвхөн өвчтэй хүн гарын үсгээ зураад өөр дээрээ туршихаас биш бусад улсууд нь өөр дээрээ туршиж болдоггүй. Албадлага байж болдоггүй.

Тийм учраас бага буурай орнууд дээр вакцин туршидаг байхгүй юу. Энэ аюултай зүйл. Жишээлбэл та нар Файзер вакциныг олон улсад, Германд, Англид, Австралид парламент дээр нь бөөн асуудал болж байгааг мэдэж байгаа байх тийм ээ. Яагаад гэвэл өндөр настай улсууд бол зүрх шигдээсний өвчнөөр бол нэлээн олноороо үхсэн нь тогтоогдсон.

Тэгээд ийм юмыг бас та нар ярьдаг байх хэрэгтэй шүү дээ. Та нар бас бусдыг боддог байх хэрэгтэй шүү дээ. Эмч нар шүү дээ. Тэрнээс биш зүгээр шууд тулгаад л вакциныг дуугүй хүлээн зөвшөөр гэж болохгүй байхгүй юу. Бүртгэлтэй тухайн орондоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хүлээн зөвшөөрсөн ийм вакцины тухай л та нар ярина уу гэхээс биш зүгээр туршигдаж байгаа вакциныг Монголд оруулж ирэх тухай ярих юм бол та нар байж болохгүй зүйл шүү.

Манай орон үнэхээр бас энэ эрх зүйн хувьд, улс төрийнхөө хувьд ч гэсэн төлөвшиж чадахгүй байна шүү дээ. Энийг далимдуулж байгаа юм гаднынхан мэдэж байгаа. Тийм учраас нэг хэсэг хүнд хэдэн доллар өгөөд л нэг доктор Стенфорд ч

байдаг юм уу Оксфорд ч байдаг юм уу том сургуулийн судалгаа хийж байгаа нөхдүүд. Тэгээд нөгөө элэгний ийм вирустэй хүн тэдэн насны хүн ийм ийм давхар өвчтэй улсуудад яаж нөлөөлөх нь вэ гэж байгаа энэ бүх судалгааг чинь хүндээр хийдэг байхгүй юу. Тэгж байж тэрний чинь сөрөг нөлөөллийг гаргадаг.

Та нар эм дээр хардаг шүү дээ. Ийм ийм улсууд хэрэглэж болохгүй ийм ийм шинж тэмдгүүд илэрвэл ингээрэй гэж. Тэрийг чинь тогтоохын тулд хүндээр туршидаг. Хулгана, амьтан дээр турисаны дараа тухайн яг тэр юугаар хүлээн зөвшөөрсөн өвчтэй хүн нь өөр дээр туршина. Тэрнээс бусад дээр туршиж бууж чаддаггүй тэр орнуудад. Тэр туршилтыг манайх шиг бага буурай орнуудад хийдэг. Манай тагнуулын газрууд ч гэсэн энэ дээр маш анхааралтай хандах хэрэгтэй. Маш том бизнес байдаг энэ бол дэлхий нийтэд. Та нар сая хараа биз дээ. Жишээлбэл КОВИД-ын вирус ямар том бизнес байв. Гадаад улс орон руу энэ вакциныг хийлгэхгүй бол оруулахгүй шүү гэдэг хүртэл лобби хийж байгаад тэр вакцинуудыг хүн рүү шахлаа шүү дээ. Маш олон хүн манайд ч гэсэн маш олон өндөр настай улсууд зүрхний шигдээс, харвах өвчнөөр энэнээс цус өтгөрөлтөөр үхсэн байгаа. Манайх бүдүүлэг орон юм чинь энэнийхээ судалгааг хийж чадахгүй байна шүү дээ. Зүгээр л эмч нар хоорондоо яриад л сууж байна. Манайд тийм судалгаа гэдэг юм байдаггүй.

Тэгэхээр би дахин хэлэхэд ер нь нөхөд минь ялангуяа энэ эрүүл мэндийн салбарын хүмүүнлэг ёсыг эрхэмлэх ёстой эмч нар минь хүн ардаа вакцины туршилт болгов. Нэг удаа болгосон шүү. Тэрний төлөө Удвал ажлаа өгсөн. Удвалын оронд өөр хүн ирэнгүүтээ яасан тэр вакциныг нь бүртгэлгүй вакциныг нь аваачиж Монголчууд дээр шахсан. Удвалыг зайлуулж байгаад. Удвал бол хүн чанартай байсан байхгүй юу. Тэрний дараагийнх нь хүн чанаргүй байсан. Монголчууд дээрээ энэ туршилтыг хийсэн.

Тийм учраас та нар энийг бодох хэрэгтэй. Би мэдэж байгаа учраас ярьж байна. Чи оролцсон бол дуугүй сууж бай. Тийм учраас би энэ вакцин ийм юмыг хийхийн тулд ийм мэтийн нөхдүүдийг ашигладаг байхгүй юу. Ард түмний тархийг угаахын тулд. Хууль, хяналтын байгууллага нь энэ дээр ажиллах хэрэгтэй шүү дээ. Би ингэж ярилаа тэгвэл хууль, хяналтын байгууллагууд анхаараад энийг шалгах хэрэгтэй. Тагнуулаасаа авхуулаад. Ийм л юм болсон байхгүй юу. Дахиж ийм.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Тэгээд санал хураалт явагдана. Гишүүд байраа эзэлье.

С.Чинзориг: Гишүүд бас өөрсдийн янз янзын байр суурьтай байгааг ойлгож байна Гэхдээ энэ Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл бас бас их тулгамдсан асуудлууд байгаа юм. Би түрүүн хэлсэн энэ умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлөөр манайх дэлхийн дунджаас 2 дахин өндөр, өвчлөлөөс шалтгаалалтай нас баралт бол бас дэлхийн дунджаас 1.5 дахин өндөр, жил тутам бол сүүлийн 5 жил үзэхэд жил тутам 350 орчим шинэ энэ умайн хүзүүний хорт хавдарт бүртгэгдэж байсан. Жилд 140-өөс 46-аас 190 бас эмэгтэйчүүд маань бас энэ хавдрын улмаас нас барж байгаа гэсэн ийм харамсалтай мэдээнүүд байгаа юм.

Тийм учраас энэ Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулж энэ товлолт вакцинд хамруулах асуудал шийдэх бас зайлигүй шаардлага байх юм. Зарим бас буруу ойлголтууд яваад байна л даа. Сая Даваасүрэн гишүүний яриад байгаа тэр харвони чинь бол вакцин биш шүү дээ. Эм л дээ эм. Энийг бол тэгээд бас ялгаж, салгаж ойлгохгүй бас энэ нийгэмд бас эхнээс нь ингээд буруу ойлголт явчих юм болов уу гэж.

Хоёрдугаарт энэ бидний энэ оруулж ирж байгаа энэ папиллома

вирусийн эсрэг энэ вакцин чинь бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн вакцин юм. Тийм учраас ямар нэгэн бүртгэлгүй вакцин оруулж ирэх гэж байгаа туршилтын журмаар хийх гэж байгаа юм шиг ийм бас ойлголт бас эхнээсээ ингээд хуулийг хэлэлцэх эсэх дээр ингээд буруу бас ойлголт явчхаж болохгүй гэж ойлгож байна бас хэлмээр байна. Ингээд гишүүд бас зөв ойлголт авч олон нийтэд зөв мэдээлэл өгөх асуудал бол их чухал.

Ялангуяа энэ Их Хурал дээр яригдаж байгаа асуудал, гишүүдийн ярьж байгаа үг хэл энэ олон нийтэд зөв бас мэдээлэл өгөхөд, зөв ойлголт өгөхөд нөлөөллийн ажлыг бас зөв бас хийх дүгнэлт чухал гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асуулт, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

54.5 хувийн саналаар төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг хэлэлцэхийг дэмжсэнд тооцон үзэл баримтлалын хүрээнд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийн асуудалд орёё.

17.18 цаг

Нийтийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулна гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.5-д Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэс болж байна гэж үзэж байна.

Улсын Их Хурлаас 2012 онд батлагдсан эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй болохыг Хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тодорхойлсон байдаг.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг 2016 онд Улсын Их Хурлаас баталж мөрдүүлсэн боловч нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрхэн зохицуулах хууль, эрх зүйн орчин өнөө хүртэл бүрдээгүй байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д Нийгмийн эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна гэж заасан боловч хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндэсний тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, тусламж үйлчилгээний төрөл, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтгүй байгаа учир энэхүү хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа 1 доллар нь ирээдүйд эмнэлгийн тусламж үйлчилгээнд зарцуулах 40 хүртэлх ам.долларыг хэмнэдэг гэсэн тодорхойлолт, судалгаа ч бас байна.

Хөгжсөн өндөр хөгжилтэй орнууд эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн 60-аас доошгүй хувийг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулдаг бол Монгол Улсад эрүүл мэндийн нийт зардлын 19 хувийг нийгмийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Түүнчлэн эрүүл мэндийн салбарын ажиллагсдын 1.9 хувь нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэт шүтсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орхигдуулсныг харуулж байна. Нийгмийн эрүүл мэнд гэдэг ойлголтод нийт хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, наслалтыг уртасгах зорилгоор авч хэрэгжүүлж буй зохион байгуулалттай арга хэмжээ хамаарч байдгийн хувьд хүн амын төрөлт, дундаж наслалт, өвчлөл, осол гэмтэл, орчин хөдөлмөрийн, эрүүл хүн амын сэтгэл зүй гээд бүх төрлийн харилцаа нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй салшгүй холбоотой байдаг.

Энэхүү хуулийн төсөлд халдварт болон халдварт бус өвчний хяналт орчин, хөдөлмөр, эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн эрүүл мэнд, гэр төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн лаборатори, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээ гэсэн 7 төрлөөр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тандалт судалгаа, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан туслан сэргийлэх, үнэлэх, хянах, нийгмийн эрүүл мэндийн бодлого, удирдлага, олон

нийтийн түншлэл, хамтын ажиллагааны чиглэлээр үзүүлэхээр заасан.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үндэсний түвшинд удирдан зохион байгуулах, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах үүрэг бүхий өвчний хяналт сэргээлтийн төв, харин орон нутгийн түвшинд аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвүүд үзүүлж байхаар тусгаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллах бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахаар тусгасан.

Нийгэм эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, олон нийтийн болон хэвлэл, мэдээллийн байгууллагын оролцоо онцгой ач холбогдлыг харгалзан тэдний, эрх, үүргийг хуулиар тодорхойлж байгаа болно.

Хуулийн төслийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа ажилтнууд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төв, Анагаах ухааны, шинжлэх ухааны их сургуулийн багш, эрдэмтэн, судлаач, доктор, ахмад ажилтан, эрдэмтэд, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, гүйцэтгэх албан тушаалтнууд оролцсон 18 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг яамны цахим хуудас, d.parliament-д байрлуулан иргэд олон нийтээс санал авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэж, дэмжиж өгөхийг хүсэж байна.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хууль санаачлагчид баярлалаа. Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны 77 хувийг халдварт бус өвчин буюу сэргийлж болох өвчлөл, нас баралт эзэлж байна.

Хууль санаачлагч хотжилт, үйлдвэржилт, хэт төвлөрөл нь эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал, химийн бодисын хэрэглээ, агаар, орчны бохирдол, хүний амьдралын буруу хэв маягаас шалтгаалсан өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа амьсгал, зүрх судасны тогтолцоо, хоол боловсруулах замын өвчлөл, хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ дутмаг байгаа хэрэгцээ шаардлагыг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзсэн тул

анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт 50.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай талаар тооцоолол хийгдсэн бөгөөд хуулийн төслийг *d.parliament.mn* цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдааны хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Одонтүяа өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үүрэг, чиглэл хуулийн төсөлд хэрхэн туссан болон хуулийн төслийн хэрэгжиж эхлэх хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа нийгмийн эрүүл мэндийн асуудал нь зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш салбар хоорондын зохицуулалтын асуудал тул хуулийг хэрэгжүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоог хангах, өвчилсөн хойноо бус, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар иргэний хүлээх үүрэг, хариуцлагын ямар зохицуулалт төсөлд тусгагдсан талаар болон ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг, санал хэлээгүй бөгөөд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх нь буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хаачсан байна. Суудалдаа сууя. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хянал шалгалт, дотоод аудитын газрын дарга Совдын Төгсдэлгэр, Цэгмидийн Эрдэнэбэлиг Эрүүл мэндийн сайдын зөвлөх, Дангаагийн Баярболд Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Аюурзанын Өнөржаргал тус яамны Нийтийн эрүүл мэндийн газрын Нийтийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Болъё, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Мөнххөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна. Чинзориг сайд машинуудаа явуулчихсан юм байна шүү дээ.

М.Оюунчимэг: Энэ хар аа Эрүүл мэндийн тухай хууль дээр бүр ингээд 13.1 дээр нь заачихсан байдаг. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндийн болоод тусламж, үйлчилгээ гэсэн 2 төрөлтэй байна гэхихсэн байгаа юм. Тэгтэл манай улсад энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дангаараа илүү ингээд хөгжөөд явчхаад, харин нийгмийн эрүүл мэнд нь энэ салбар нь бүр орхигдчихсон. Тийм учраас энэ нийгмийн

тусламж, үйлчилгээ нь ачааллаа даахаа байгаад урвуу хамааралтай ингээд болчихоод байгаа юм.

Гэтэл хэрвээ бид нийгмийн эрүүл мэндийн салбартаа түлхүү анхаарал хандуулж төсөв мөнгөө төсөвлөөд явж байсан бол өнөөдөр энэ хүн амын өвчлөл, нас баралтын тоо маш бага байх бололцоо байсан. Даанч ингэж чадаагүй. Тэгээд нийгмийн эрүүл мэнд гэдэг ойлголт нь ч бараг хүмүүст муу ингээд явж ирчихсэн юм. Тэгэхээр бид нар өнөөдөр яриад байгаа нь нийгмийн эрүүл мэнд гэдэг өөрөө ямар ач холбогдолтой юм бэ. Та бүхэн аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд нийгмийн эрүүл мэнд чухал ач холбогдолтой. Тэгээд нийгмийн эрүүл мэнд гэдэгтэй юу орох юм, хүүхдийг багаас нь спорт, биеийн тамираа хичээллүүлдэг байх гэдэг юм уу, агаар, хөрсний бохирдлоос өөрийгөө яаж хамгаалах юм гээд урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч чаддаг. Энэний үр дүнд хүн өөрөө эрүүл байх гол шалтгаан болдог.

Өнөөдөр өндөр хөгжилтэй нөгөө ёстой аз жаргалын индексээрээ эхний гуравт орж байгаа орнууд байдаг Норвег гээд л, Люксембург гээд ярихад нийгмийн эрүүл мэндийг бүүр нэгдүгээрт тавьчихсан байдаг. Хүн бүхэн яг заавал гүйдэг гэдэг юм уу, усанд сэлдэг байх ёстой ч гэдэг юм уу бүүр тэр нь боловсролоосоо, цэцэрлэгээсээ ингээд хүмүүжээд явчихсан. Манайд энэ нь бүүр орхигдчихсон. Тэгээд өнөөдөр энэ хуулийг оруулж ирж байна. Бид бас энэ хуулийг оруулж ир гэж тухайн үеийн салбарын сайдууд мөн ч олон удаа бас шахсан Нийгмийн бодлогын байнгын хороо. Тэгээд өнөөдөр ингээд орж ирж байна л даа. Энийг бид бас зайлшгүй, цаг алдалгүй баталж гаргах ёстой хууль байгаа.

Бид бас 23 оны төсөв хэлэлцэх үед нийгмийн эрүүл мэндийн чиглэл тэр дундаа энэ спортоор хичээллэх, биеийн тамирын заалнууд болон бусад энэ арга хэмжээнүүд дээр илүү түлхүү анхаарч татварын бодлогоор ч юм уу бусад

бодлогоор дэмжих гэсэн асуудлуудад тавьж байсан. Гэхдээ тухайн үедээ хууль нь орж ирээгүй учраас төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал бас ишидэгдэж чадаагүй.

Тэгэхээр одоо энэ хуулиа дагаад 24 оны төсөвт яг төсөвлөж байгаа зүйл юу байна. Энэ дээр Боловсролын багц хууль хүртэл өнөөдөр бид орж ирээд эцсийн хэлэлцүүлгийг нь хийх гэж байна. Энэ чинь ганц эрүүл мэндийн салбарын ажил биш, бүх салбар хамааралтай асуудал байгаа.

Тэгэхээр энэ бусад салбаруудтайгаа яг энэ Нийгмийн эрүүл мэндийн хуулийг гаргахад хэр ингэж хамтарч ажиллаж, тэдний байр суурь, санал бодлын тусгасан бэ. Энэ дээр би товч хариулт авъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Үнэн л дээ. Бид ер нь бол энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийхээ асуудалд хэт бас анхаараад нөгөө тал болсон энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг бас орхигдуулж ирсэн. Ирсэн байна гэдэгтэй санал нэг байгаа. Бусад өндөр хөгжилтэй орнуудын туршилагыг ч гэсэн харахад энэ нийгмийн эрүүл мэндэд болоод анхан шатын тусламж, үйлчилгээ нь нийт энэ иргэдийн эрүүл мэндийг хамгаалах энэ тусламж, үйлчилгээний чинь 50-60 хувь нь бол энэ шатдаа байдаг. Хөрөнгө санхүүгийнх нь 50-60 хувийг нь нийгмийн эрүүл мэнд анхан шатын тусламж, үйлчилгээндээ зарцуулдаг. Манайх бол үүний уруу болчихоод байгаа юм. Би түрүүн хэлсэн санхүүжилтийнхээ 19 хувийг л бид нийгмийн эрүүл мэнд, анхан шатынхаа тусламж үйлчилгээнд зарцуулж байна гэж.

Тэгэхээр бол бид нар энэ дээр нэлээн тийм бодлогын тогтолцооны зайлшгүй өөрчлөлтийг хийх шаардлагатай. Энэ хүрээнд энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний

хууль гээд ийм анхдагч хуулийг оруулж ирж байна. Бид хэд хэдэн асуудлыг бол шийднэ.

Ер нь бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэг бол зөвхөн Эрүүл мэндийн яамны асуудал биш ээ. Энэ бол үндсэндээ салбар хоорондын уялдаа, зохицуулалт шаардсан орчны эрүүл мэндийн асуудал, агаарын бохирдлын асуудал, хөрсний бохирдлын асуудал бүх л асуудлууд энд хамаарагдана.

Тийм учраас бол бүтцийн хувьд бол Ерөнхий сайдаар ахлуулсан ийм Үндэсний зөвлөл ажиллуулъя гэж оруулж ирж байгаа.

Хоёр дахь асуудал нь бид шинээр бүтэц, цоо шинэ бүтэц бий болгохгүй, орон тоо нэмэхгүйгээр одоогийн байгаа бүтэц орон тоондоо багтаагаад өвчний хяналт, сэргээлтийн төв буюу олон улсынх нь нэрилээр CDC-ийг бас энэ улсын хэмжээнд бас ийм бүтэц бас бий болгохыг бол зорьж байгаа.

Санхүүжилтийн хувьд бол бид нар эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтийн аргаар санхүүжилт авч байгаа ингээд бүх юм сайхан болж байгаа гэж хэлэхэд арай бас боломжгүй байгаа.

Ялангуяа энэ нийгмийн эрүүл мэнд тусламж, үйлчилгээний санд зарцуулах санхүүжилтийг улсын төсвөөс шууд бас санхүүжүүлдэг байх. Эмнэлгийн тусламж үйлчилгээгээ эрүүл мэндийн даатгалаасаа, эрүүл мэндийн байгууллагынхаа сангаас гүйцэтгэлийнхээ санхүүжилтийн аргаар авдаг байх ийм тогтолцоо руу бол орохыг бол зорьж байгаа гэдгийг хэлье.

Шинээр бол бид ирэх жил 50 орчим тэрбум төгрөг нэмэлтээр шаардана гэж тооцно. Гэхдээ энэ 50 хувь нь бол улсын төсөв дээрээс санхүүжилт авахаар төлөвлөж байгаа. 50 хувийг нь олон улсын байгууллагууд тийм санхүүгийн

дэмжлэгийн хүрээн дээр санхүүжүүлж болох юм. Тухайлбал манайд энэ олон жил хамтарч ажиллаж байгаа Глобал сан эд нар гээд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр бас ажилладаг ийм байгууллагуудын санхүүжилтээр явах бас ийм бүрэн боломжтой гэж үзэж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль үнэхээрийн чухал хууль байгаад байгаа юм. Энэ хуулийг бид үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж, маш яаралтай баталж гаргах ёстой гэсэн ийм байр суурьтай.

Нийгмийн эрүүл мэнд гэдгээ биднүүс хүн байгаль, нийгмийн зохицол л гэж үнэхээрийн л үзэж байгаа бол энэ хууль дотор энэ асуудлыг авч явах үндэсний хороо хийгээд салбар хороодын асуудлыг ер нь яаж томъёолж оруулаад байгаа юм бэ. Энэ бол яах аргагүй салбар хоорондын зохицуулалтаар хэрэгжих ёстой ийм зүйл. Үүнийг яаж оруулж байна вэ гэж.

Хоёр дахь зүйл ерөөсөө анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын чинь үндсэн чиг үүрэг энэ. Тийм учраас энэ чиг үүрэгтэй нь уялдуулж энэ эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэгт ямар өөрчлөлт орж байгаа вэ гэдэг асуудал байна.

Гуравдугаарт 1 хүнд ноогдох нормативт хувьсах зардал гэдгийг бид тогтоож өгч байж энэ нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа жинхэнээ явах бололцоо боломж нь бүрдэнэ. Дан дамаа тэр анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд руугаа 1 хүнд ноогдох нормативт хувьсах зардлаар хөрөнгө мөнгө нь шилжиж явдаг байж байж энэ шийдэгдэнэ.

Дараагийн нэг зүйл бол би энэ яагаад хороо гэж ярьсан бэ гэхээр зэрэг

сумын түвшинд хурлын дарга нь байдаг юм уу, Засаг дарга нь байдаг юм уу ахалсан хороо байж байж наад хүрээлэн буй орчны чинь нөлөөлөл, сөрөг нөлөөлөл буурах учиртай. Ариутгах татуургаасаа авхуулаад ногоон байгууламж, зам талбайнх нь бүх асуудал шийдэгдэх ёстой.

Тэгэхээр зэрэг үүнийг бид дан ганц эрүүл мэндийн байгууллагын ажил мэтээр эднүүс дээр үүрүүлэх гэж оролдвол энэ дэндүү удааширсан бас үр дүнгүй юм болж хувирна шүү. Тийм учраас энэ хуулийг нэгэнтээ бид батлан гаргаж байгаа бол хэрэгжих боломж тэгээд үзүүлэх үр дүн үр, нөлөөг дээшлүүлэх үүгээрээ дамжиж иргэдийнхээ эрүүл мэндийг дэмжин хамгаалах үйл явцаа л хийх ёстой.

Дээр нь энэ Бат-Эрдэнэ сайдтай нэлээн сайн хамтарч ажиллаж байж энэ нийтийн биеийн тамирынх нь чиглэл буюу тэр хөдөлгөөнөөр дамжсан хүнийг эрүүлжүүлэлтийн асуудал нь явагдах байх. Ийм хэдэн зүйлийг энэ хуульд ер нь ямархуу байдлаар томъёолж зохицуулж оруулав. Үүн дээр тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: 83 ажлын хэсгийг хариулъя.

Д.Баярболд: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярболд байна. Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд энэ таны асуусан зөвлөл, хороодыг ямар байдлаар зохион байгуулж байна гэж байгаа. Тэгэхээр эрүүл мэндийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан эрүүл мэндийн нийгмээс эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэлэлцэх үндэсний зөвлөл байгаа. Энэ зөвлөлөөр бас яг энэ нийгмийн эрүүл мэндийн асуудлыг жил бүр оруулж, шийдвэр гаргаж, салбар хоорондын уялдаа холбоог хангахаар зохицуулсан. Энэ журмыг Засгийн газар батална.

Эндээ бас нэгж, засаг захиргааны нэгж болгондоо бас энэ зөвлөлүүдээ байгуулаад энэ зөвлөлөөрөө дамжуулаад салбар хоорондын уялдаа холбоогоо хангаж явахаар бол зохицуулсан байгаа.

Анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд бүтцийн өөрчлөлт орохгүй. Харин энэ өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтнийг заавал ажиллуулна гэдгийг оруулж өгсөн байгаа.

Норм, нормативын асуудал ярьж байна. Энэ нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлыг энэ хуулийн төслийн 15 дугаар зүйлд оруулж өгсөн байгаа. 15.4 дээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, санхүүжих төлбөртэй санхүүжүүлэх, төлбөртэй тусламж үйлчилгээний асуудлыг бол зохицуулж өгсөн.

Тэгэхлээр нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний багц гараад жилд тухайн орон нутаг ямар хэм хэмжээний нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг вэ гэдгээрээ санхүүжилтээ тавиад энэ бол улсын төсвөөр санхүүжүүлэхээр бол тусгагдсан байгаа хуулийн төсөлд. Баярлалаа.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулъя. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулна.

Ж.Батжаргал: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц гэж гаргаад хэдий хэмжээний хүн үйлчилгээ авсан бэ гэдгээрээ санхүүжнэ гээд гүйцэтгэлийн юм болоод байна л даа. Би бол ярьж байгаа нь 1 хүнд ноогдох нормативт хувьсах зардал тогтоогоод өгчих. Тэгээд тэр сум 2000 хүн амтай бол тэр нормативт хувьсах зардлаа 2000 хүнээрээ үржүүлээд авдаг байг. Яг тэрэндээ таарсан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ явуулдаг

байг. Тэгж байж наад хүн амын чинь эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндээ дэмжин хамгаалах үйл явц энэ бүх юм чинь хэрэгжинэ. Тэгэхгүй орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад тавигдсан хүн нь ямар байгаагаас ямар үйл ажиллагаа явуулахаас хамаараад санхүүжилтийн багцтай явах юм бол наадах чинь дэндүү ялгаатай хийгээд, үр нөлөөгөө ойрын хугацаанд үзүүлэхгүй. Тийм учраас одоо бид энэ анхан шатын эрүүл мэндийн.../минут дуусав./

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Батжаргал гишүүнтэй үндсэндээ санал нэг байгаа юм. Одоо манайд бол энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар эрүүл мэндийн байгууллагаас санхүүжилт авч байна гээд ингээд явчихлаар бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудал бол үнэхээр болохгүй байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас бид нар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийхээ хуулиар ямар ч байсан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсөв өөрөө улсын төсвөөс санхүүжүүлнэ гэдгээ ялгаж, салгаж өгч байгаа нь маш чухал гэж бодож байна.

Хоёр дахь асуудал нь иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх асуудал бид үнэхээр онцгой анхаарах ёстой. Үндсэн хуульдаа бид эрүүл мэндээ хамгаалах нь иргэний журамт үүрэг гэсэн ийм Үндсэн хуулийн заалттай. Энийг ерөөсөө ярьдаг хүн байдаггүй, мэдээлэл өгдөг, ойлголт өгдөг хүн байхгүй. Ядаж бид нар энэ Нийгэм эрүүл мэнд тусламж, үйлчилгээний тухай хуультай бол иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар томоохон бас арга хэмжээ авах. Ер нь энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний асуудал зөвхөн Засгийн газрын хийх ажил, бас иргэд, иргэний оролцоо, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоо, хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоо, тал

талын л оролцоо асар их өндөр байж байж.../минут дуусав./

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлага байгаа, ойлгож байгаа, дэмжиж байгаа. Ер нь энэ чухал энэ асуудлуудыг оруулж ирж байгаа Чинзориг сайд бас талархалтай байна.

Яг хуулийн төслийг үзэх юм бол бас хэлж засах, залруулах зүйлүүд нэлээд байна. Өнөөг хүртэл Эрүүл мэндийн тухай хууль болон Нийгмийн эрүүл мэндийн тусгайлсан хуулиудаар энэ асуудлууд зохицуулагдаад ирсэн. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр бие даасан тусдаа хууль гарч байгаагийн хамгийн гол ач холбогдол нь эрүүл байх, эрүүл мэндийг хамгаалах нь зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш гэдгийг хуульчлан ойлгуулах гэж би хувьдаа хараад байгаа байхгүй юу. Энэ өнцгөөс харахад хууль төдийлөн хангалттай боловруулж чадаагүй байна. Нөгөө л тусламж үйлчилгээ үзүүлж, нөгөө нь авдаг харилцаа, хандлага хэвээрээ тусаж байна. Зүй нь бол хамтын хүчин чармайлт, нийтээрээ эрүүл байх нь бүх нийтийн үйл шүү гэдэг үзэл нэвт шингэсэн хууль байх ёстой юм. Тэгэхлээр энэ үзэл санаа энэ хуульд ингээд уншихлаар төсөл дээр харагдахгүй байна.

Юуны өмнө бусад салбаруудын хүлээх үүргийг салбар бүрээр тодорхой зааж оруулах нь зүйтэй. Хуулийн төслийн 6.7 дахь заалт хангалтгүй байна. Хэвлэл мэдээллийн салбар ямар үүрэгтэй байх юм, боловсролын салбар, барилга, хот байгуулалт яах ёстой гээд үндсэн чиг үүргүүдэд нь тавьж өгмөөр байна. Зөвхөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран асуудлыг нь тусад нь оруулсан төсөл байна тийм ээ. Эрүүл мэндийн боловсролыг төлөвшүүлэхэд боловсрол, соёл, урлаг, хэвлэл мэдээллийн салбарын оролцоо зайлигүй байх жишээтэй.

Гэтэл энэ хуульд бүх нийтийн эрүүл мэндийн боловсролын талаар огтхон ч дурдаагүй байх жишээтэй. Энийг залруулъя. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллагын чиг үүрэгт төслийн 8.1 дэх заалт шүү. Бусад салбаруудтай хамтран ажиллах, бусад салбаруудын тэргүүлэх байгууллагыг чиглүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх талаар огт тус бодогдоогүй байна. Эрүүл мэндийн салбар өнөөг хүртэл нийгмийн эрүүл мэндийн талаар хийх ажлаа энэ хуультай хийсээр ирсэн, хийх ч болно.

Харин бусад салбарт манлайлал үзүүлж, нийтийн эрүүл мэндийн үйлсэд хувь нэмэр оруулах уриалан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүргээ болон бусад салбарын оролцоог хуульчлах нь илүү чухал гэж харж байгаа юм. Бас нэг зүйл нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг бүрдүүлэхэд төрийн бус байгууллагууд орон нутгийн засаг захиргаа санхүүгийн салбар ямар үүрэгтэй юм, ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалахад ажил олгогчид, аж ахуйн нэгжүүд ямар үүрэгтэй байх вэ. Иргэд чөлөөтэй биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлэхэд аймаг, нийслэлийн Засаг захиргаа ямар үүрэгтэй байх вэ зэргээр нийтийн эрүүл мэндийн нийтийн үйлс болоход энэ хууль ямар нэмэр үзүүлж байгаа юм. Энийг бас тодруулж хэлээч.

Тэгээд ер нь Монгол хүний эрүүл амьдарч аж төрөх нэгдсэн стандартыг бүгд хамтарч бүтээнэ л гэсэн энэ хууль өөрөө энийгээ баталгаажуулах ёстой юм. Дараагийн жишээ гэхэд иргэдийн эрх, үүрэг хэсгээс харахад дархлал судлалд шаардлагатай мэдээлэл өгөх, хорио цээрийн шаардлагыг биелүүлэх гэх мэт олон улсын нөгөө эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдсан харилцааг түлхүү барьсан шинжтэй байна. Гол гол чухал үүргүүдийг бид оруулахгүй бол энэ КОВИД, цар тахлын үед сурсан зүйлүүдээ бид энд зайлиггүй оруулах шаардлагатай байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт бүлэг гэх гэхэд л 15.1-д бас л нөгөө эрүүл мэндийн салбарынхны салбарын л үүрэг гэдэг зарчим хэвээрээ хадгалаастай байгаад байгаа юм. Тухайлбал нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандиваас бүрдэнэ гэхчээр иргэн, аж ахуйн нэгж зөвхөн хандив өгөхөд л болно гээд хуульчлаад байгаа байхгүй юу. Бид энэ төрийн оролцоо төсөвт суулгах асуудлуудыг бид илүү их хуульчилж өгөх ёстой шүү дээ. Тэгээд олон улсын байгууллагын оролцоог зохицуулах шаардлагагүй гэж үзэж байгаа бололтой.

Ер нь тэгээд олон улсын сая Чинзориг сайд олон улсын донор байгууллагын санхүүжилт авна гэж ярьж байгаа юм. Тэгвэл энэ хуульдаа бас тэрийгээ оруулъя л даа. Ер нь боловсруулалтын хувьд чамбай суугаагүй байгаа л гэж харагдаад байна. Тийм учраас энэ дээрээ хэдүүлээ дэмжээд ажлын хэсэг дээрээ илүү их чамбай ажиллаж энэ Монгол хүн эрүүл амьдарч, аж төрөх нэгдсэн стандарт бүгд хамтарч бүтээнэ гэсэн энэ.../минут дуусав./

Г.Занданшатар: Үг хэллээ. Тийм үү. Зарим нь асуулт байна уу. Асуулт байгаа асуулт. Чинзориг сайд, Содномын Чинзориг сайд хууль санаачлагч хариулъя.

С.Чинзориг: Чинбүрэн гишүүний санааг үндсэндээ саналууд байна гэж ойлгожээ. Хэрвээ гишүүд дэмжээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд анхны хэлэлцүүлэгт шилжүүлбэл Байнгын хороо ажлын хэсэг байгуулаад, тэр ажлын хэсэг дээр бас нэлээн чамбайруулж ажиллах шаардлага байх болов уу гэж л бодож байна.

Хоёр дахь асуудал нь одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиуд байна тухайлбал, Эрүүл ахуйн тухай хууль гээд л хууль байгаа тиймээ. Тэгэхээр энэ хуульд байгаа юмнуудыг бид нар бас энэ хууль руу

нэг харахлаар бол нэг хуулиар зохицуулагдмаар асуудлууд байдаг. Тэгээд энийг бас заримыг нь оруулаагүй ингээд хүчин төгөлдөр байгаа хуулиудтай бас давхцуулахгүй эд нар гэдэг ийм санаагаар бол бас орсон юманд байгаа.

Харин тодорхой хэлэхэд санхүүжилтийн асуудлыг нь бүүр тодорхой болгож өгье л гэж би тэгж ойлгож байгаа юм. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг ерөөсөө улсын төсвөөс өөрөө шууд санхүүжүүлнэ л гэж байгаа юм. Одоо бол бид нар энэ гүйцэтгэх санхүүжилтийн аргаар чинь явахлаар бол өвчний хяналт, тандалт, судалгаа, элрүүлгийн асуудал чинь энэ гүйцэтгэлийн санхүүжилтээр явах ямар чаргагүй болчихоод л байна л даа.

Тийм учраас бол Нийгмийн эрүүл мэндийн тухай тусламж, үйлчилгээний тухай хуульд оруулж ирж байгаа энэ асуудал бол ерөөсөө нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ гэдгийг маш товч тов тодорхой бичиж өгч байгаа юм. Энүүгээрээ давуу талтай. Тэгээд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ тэр эрүүл мэндийнхээ даатгалын сангаас гүйцэтгэлийнхээ санхүүжилтийн аргаар явдаг байх асуудлыг оруулж өгч байгаа. Ийм асуудлууд байна.

Нөгөө талдаа тэр салбар хоорондын уялдаа, зохицолтой холбоотой асуудлууд асар их байна. Ялангуяа бид нар иргэддээ энэ амьдралын зөв хэв маяг бас төлөвшил асуудал маш их ярих хэрэгтэй бол байна. Буруу дадал зуршилд өртөхгүй байх, буруу дадал зуршлаас салах эд нар гээд ер нь бол энэ олон улсын байгууллагуудын судалгаа, эрдэмтдийн судалгаа эд нар чинь хараад байхлаар иргэн хүний эрүүл байх, урт наслахын асуудлыг чинь 50 хувь нь иргэн хүнтэй өөрөөс нь шууд хамааралтай гэсэн ийм нотолгоо, судалгаанууд байгаад байна шүү дээ. Тэр иргэн хүний өөрийнх нь эрүүл байх, урт наслахынх нь 50 хувь нь өөртэй нь, өөрөөс нь шууд хамааралтай байгаа

бол тэр иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх асуудлыг нэлээн өндөр түвшинд гаргаж хөгжүүлэх, дээр нь энэ салбар хоорондын уялдаа холбоонууд байна.

Ялангуяа энэ биеийн тамир, спортын асуудал, нийтийн биеийн тамир, хөдөлгөөн дасгал сургалтын асуудлууд эд нар гээд энэ асуудлууд руу нэлээн тийм салбар хоорондын уялдаа зохицуулж шаардсан асуудлууд байгаа. Энэ бол шинэ, анхдагч хууль учраас бас дутуу харсан юмнууд чинь бас байхыг үгүйсгэхгүй. Энийгээ бид нар чамбайруулаад, ажлын хэсэг дээрээ яриад ингээд намрын чуулганаар анхны хэлэлцүүлгийг нь хийж, эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн ийм л байр суурьтай байх.

Г.Занданшатар: Байна уу. Одоо Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Би энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Энэ хууль юуны хүрээн дээр нь олон ч төсөл, хөтөлбөр хэрэгжсэн. Өсвөр үеийн, тамхины, халдварт өвчний талаар, халдвартай халдварт бус өвчний талын, хүн үржихүй гээд, иод дутагдлын эмгэг гээд. Гагцхүү энэ хэрэгжсэн мөртөө тогтвортой ингээд явуулах гэхээр чинь шалтгаан нь энэ Эрүүл мэндийн сайдуудад солигдоод явчихдаг. Тэрийг дагаад газар, хэлтсийн дарга нар нь бас солигддог. Тэгээд нөгөө ирсэн улсууд нь ажил явуулах гэхээр чинь жил юм уу, жилийн дараа солигддог ийм хүндрэл байгаа л даа. Тийм учраас энийг тогтвортой ажиллуулмаар байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ яаралтай тусламжийн машиныг энэ гишүүд байгаа дээр нь ер нь Оросын фургоноос татгалзах цаг болсон. Өвчтэй, гэмтэлтэй улсуудыг эрүүл мэндийн салбарын эмч нар өдөр, шөнөгүй өвлийн хүйтэнд ингэж явж байснаас ер нь цаашидаа энэ туулах чадвар сайтай, донсолгоо багатай тийм машин энэ

талаа төсөвтөө шийдэж өгөх шаардлагатай байна.

Нөгөө талаар энэ Эрүүл мэндийн сайдын багц дээр та нар битгий татгалзаач. Ноднин бид нар 60 хэдэн тэрбум төгрөг тавьчхаад батлагдсан байх гэсний дараа хасаад хаячихсан байна. Тэгээд мөнгө байхгүй сайд нь юугаа хийх юм ер нь. Тийм учраас энэ дээр анхаарч дэмжиж өгөөч гээд хүсэлт тавимаар байна.

Дараа хоёр асуулт байна. Яаралтай тусламж байна. Түргэн тусламж аймаг, хотынх мөн адилхан. Хот их тэлж байна, хүн ам ихсэж байна. Аймаг мөн адилхан. Түргэн тусламжийн хүний нөөц, хүчин чадлыг судалсан уу ер нь. Одоогийн үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ тэр түргэн үйлчлэх чадвар нь хэр байна. Заримдаа түргэн оройтож очиж байна. Энэ чинь бас аймагтаа ганц түргэнтэй. Мөнгө төсөв нь шийдэгдээгүй, бензин шатахууны төсөв нь бага учраас. Нэг л түргэн явуулдаг. Заримдаа халдварт өвчин гарсан үед нь 2 түргэн явуулдаг л байх. Энийг шийдэж өгөөд та нар дэмжиж өгөөч гээд хэлмээр байна.

Хоёр дахь асуудал энэ төсөл, хөтөлбөр олон ч төсөл, хөтөлбөр хэрэгжсэн дээ. Ер нь НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, ЖАЙКА, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Монгол Улсын Засгийн газар энэ чиглэлээр ч гэсэн. Одоо яг хэчнээн ер нь сүүлийн 30 жил хэчнээн төсөл хэрэгжсэн байна хөтөлбөр. Одоо ер нь хэчнээн төсөл, хөтөлбөр хэрэгжээд явж байна. Засгийн газрын шийдвэр гараад бүгдийг нь зогсоосон юм байна. Энэ дээр дүн шинжилгээгээ хийсэн үү. Энэ хоёр асуудал асууя.

Гурав дахь нь энэ нийгмийн өвчин гарахаас өмнө өвчин гараад эмчлэх биш энэ урьдчилан сэргийлэх ёстой л доо бид нар. Тийм учраас энд Монгол Улсын Засгийн газар аймаг, сумын Засаг дарга нар энийг бүгдийг нь оролцуулах ёстой бид нар. Тэгж байж хамтарч байж

шийдэхгүй бол ялангуяа хэвлэл, мэдээллийн байгууллагууд байж байна. Радио телевизээр сайн сурталчилгаа хийх хэрэгтэй.

Ер нь сургалт, сурталчилгааны хувьд сургуулийн багш нар, эмнэлгийнхэн, Засаг дарга нар, хурлын дарга нар ер нь бүгдийг нь сургасан даа. Уламжлалаа цаашаа аваад явчихгүй тийм асуудлууд байж байна. Цаашидаа энэ хуулийн хэрэгжилтэд ер нь төр захиргаа бүгд оролцож байж энэ хамтраад шийдэхгүй бол энэ өвчлөл ихэснэ. Одоо хавдрын өвчлөлөө хараарай залуужиж байна. Хөдөө аж ахуйн яам бас оролцох ёстой. Хүнсний хортой бүтээгдэхүүн байна уу. Би л харж байгаа энэ хүнсний дайн явагдаж байгаа юм биш биз. Хавдар залуужиж байна, янз бүрийн өвчин гарч байна. Энэ дээр бас судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай. Сая багш нь ярьж байна. Багш энэ хоруу чанарыг бас судлах ёстой. Эрдэм шинжилгээний байгууллагууд. Энэ талаараа хамтарч байж энэ хууль хэрэгжих байх. Саяын хоёр асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: 81, 81 хариулъя.

Д.Баярболд: Бейсен гишүүний асуултад хариулъя. Яаралтай тусламжийн хувьд бол эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөлд багтаад Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулагдаж явагдаж байгаа. Энэний хувьд бол хүртээмжийг нь нэмэгдүүлэх тэгээд 20 минутын дотор тусламж, үйлчилгээ хүргэх асуудал бол ялангуяа нийслэл Улаанбаатар хотод замын нөхцөл байдал, түгжрэлтэй холбоотойгоор нэлээн асуудал дагуулдаг.

Гэхдээ сүүлийн жилүүдэд нийт дуудлагын 60 орчим хувийг 20 минутад хүргэх ийм бас ахиц, дэвшил тодорхой хэмжээгээр гарсан байгаа. Цаашидаа яаралтай тусламж, үйлчилгээг Азийн хөгжлийн яамны төслийн хүрээнд төвлөрлийг сааруулах, үйлчлүүлэгчид ойртуулах, дүүргүүдэд нь байршуулах энэ

зохион байгуулалтын ажлыг хийхээр төлөвлөөд төсөл хэрэгжиж байгаа.

Нийт эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн тухайд гэвэл яг яамны удирдлага доор үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа 23 төсөл, хөтөлбөр байгаа. Үүнээс гадна эрүүл мэндийн байгууллагууд хоёр талт хамтын ажиллагаа, олон талт хамт ажиллагааныхаа хүрээнд тус бүрдээ төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлээд нэн чухал нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бол төслийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Г.Занданиатар: Содномын Чинзориг сайд.

С.Чинзориг: Сая үндэсний зөвлөл тогтоол гаргаад Үндэсний зөвлөлийн 4 тогтоолд өөрчлөлт торуулсан. Өчигдөр Хууль зүйн яам энэ Үндэсний зөвлөлийн тогтоолуудыг бүртгэсэн. Ингээд энэ 7 сараас хэрэгжиж эхэлнэ. Энэ хүрээндээ бид нар энэ сумын эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжилтийн хувьд дэмжих, ялангуяа төвөөс алслагдсан, цөөн хүн амтай сумуудыг санхүүгийн хувьд бас бэхжүүлэх, хэвийн үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх зайлиггүй шаардлагууд байгаа. Энэ чиглэлийн тохируулгуудыг хийж өөрчилсөн.

Тантай бол санал нэг байна. Энэ хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагуудыг туулах чадвар сайтай түргэний унаагаар хангах шаардлагатай. Ний нуугүй хэлэхэд Оросын Холбооны Улсад үйлдвэрлэсэн УАЗ-469 фургон гээд машиныг бид нар олон жил ашиг ашигласан. Энэ бол үндсэндээ тэгээд яаралтай тусламжийн шаардлага хангадаггүй, хүнд өвчтэй хүнийг тээвэрлэхэд маш хүндрэлтэй. Тэгээд бас эдэлгээний бас хугацаа ч богино байдаг ийм асуудлууд багаа.

Тийм учраас бол энэ оноос эхлээд сумдын эрүүл мэндийн байгууллагуудыг туулах чадвартай ийм түргэний унаагаар хангах арга хэмжээ авна. Дэлхийн банкны санхүүжилтийн хөрөнгөөр бид нар энэ ондоо багтаагаад нийт 330 сумын 30 хувийг ямар ч байсан эхний ээлжид туулах чадвартай автомашинаар бас хангахаар төлөвлөж байгаа. Ондоо багтааж авна. Японы ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтраад бүх аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг бас алсын дуудлагад явах шаардлагатай, туулах чадвартай автомашинаар хангах арга хэмжээ авч байгаа. Амжвал бид нар энэ 7 хоногт наадмын өмнө энэ машин, автомашинуудыг аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд бас хүргэхээр бол ажил зохион байгуулж байгаа. Ингээд дэс дараатайгаар сумдын болоод аймгийн эрүүл мэндийн байгууллагуудыг алсын дуудлагад гүйцэтгэх чадвартай, туулах чадвартай машинаар автомашиныг хангах арга хэмжээ авч байна.

Тантай би санал нэг байна. Энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор энэ санхүүжилтийн асуудлыг тодорхой болгож өгөхгүй бол одоогийн энэ гүйцэтгэлийн аргаар чинь явахлаар Нийгмийн эрүүл мэндийн сан асуудал бол санхүүжилт нь авч чадахгүй хоцроод байгаа. Ялангуяа энэ өвчний тандалт, хяналт судалгаа, илрүүлэг эд нар чинь яг ингээд гүйцэтгэх санхүүжилтээр явуулаад санхүүжилтээ ав гэхлээр чинь өвчнийг урьдчилж бид нар ямар төрлийн өвчин дэгдэх, ямар шинэ төрлийн вирус дэгдэх магадлалтай байна вэ гэдгийг судалж тандалт хийж, хяналт хийж чадахгүй өвчин илэрсэн хойно л түүний араас л хөөцөлддөг ийм л нөхцөл байдалтай болчихоод байна шүү дээ.

Тийм учраас бол энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ улсын төсвөөс санхүүжүүлдэг болно. Дээр нь энэ халдварт ялангуяа энэ халдварт өвчинтэй тэмцэхтэй холбоотой энэ тандалт, хяналт, судалгаа, илрүүлэхтэй холбоотой асуудлыг бол улсын төсвөөс

санхүүжүүлдэг ийм болох ийм тогтолцоотой болгоно.

Ер нь тогтолцооны хувьд бид нар нийгмийн эрүүл мэндийн төвийг түшиглээд Халдварт өмчин судлалын үндэсний төвийн тандалт, хяналт, судалгааны хэсгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик, мэдээллийн хэсгүүдийг нэгтгээд ингээд өвчний хяналт, сэргэлтийн төв болгоод явах ийм бас бүтэц, тогтолцоо руу оруулъя гэсэн ийм чиглэлээр хуулийн төсөл оруулсан. Ингэж чадаад, бүтэц хийж чадаад тэгээд санхүүжилтийнхээ асуудлыг, нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн улсын төсвөөс шууд санхүүжилт авдаг байхаар тогтолцоо хийж чадвал нэлээн тийм чанарын бас ахиц өөрчлөлт гарах болов уу гэж бол хүлээлт байна.

Г.Занданшатар: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энэ тусламж үйлчилгээ дээр бас нэг энэ түгжрэл, дээр үед чинь нисдэг тэрэг юм уу онгоц авах бодлого байна уу төсөвт тийм оруулах санал байна уу. Ер нь бас дотор цус алдалт, хүнд гэмтлийн үед чинь хот дотор ингээд зөөчихдөг тийм нисдэг тэрэг аймаг, сум, хөдөө аймгууд дээр үйлчлэх тийм онгоц авах бодлого бий юу, хөдөөгөөс ингээд онгоц тээвэрлэхгүй байна. 1 хүн явахад 4-5 хүний зардал авдаг ийм өндөртэй нөхцөл байдал байна шүү дээ. Одоо энэ манай энэ үед чинь Орос 69, фургон хоёр чинь үүргээ гүйцэтгэсэн гүйцэтгэсэн хөөрхий амьтан ажилласан, сайн явсан бид нар. Одоо энэ талаар түргэн тусламжийг шинэчлэх тал дээр ямар бодлого байна. Цаашидаа энэ төсөв дээр юм тавиулах уу та бүгд, гишүүд дэмжих болов уу ер нь. Дэмжсэн нь зөв байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Энэ ер нь нисдэг тэрэгтэй байх ч буруу биш. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тийм би хоёр зүйл хэлээд орхиё. Түрүүн гишүүд

маань тодорхой санал хэлж байна. Арга байхгүй Их Хурлын гишүүд энэ оруулж ирж байгаа хуулийн цаад санааг бол мэдээд дахин дахин хэлээд байна шүү дээ. Түрүүн Батжаргал гишүүн хэллээ бас өөр бусад гишүүд ч хэлсэн. Энэ нийгмийн эрүүл мэндийн тухай асуудал ярих юм бол хүн амынхаа эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадал хэвшилийг яаж бий болгох юм. Тэрийг бий болгодог соёл арга нь бол хүн төрөлхтөн чинь биеийн тамир, спорт гээд тов тодорхой байж байгаа шүү дээ. Тэгээд тийм учраас энэ асуудлуудыг яриад байгаа юм. Яагаад би энэ цаанаа ийм нуугдмал юм байна гэж ингэж хэлж байгаа вэ гэхээр зэрэг манай биеийн тамирын салбарынхан Эрүүл мэндийн яаманд олон жил явсан. Эрүүл мэндийн яамны бодлогод бол үнэхээр байр сууриа эзэлж байж чадаагүй. Үе үеийн Эрүүл мэндийн яам, сайд нар ерөнхийдөө биеийн тамир спортыг дандаа үлдэгдлийн зарчмаар нөгөө шоовдор хүүхэд гэдэг шиг ийм хаяанд суулгаж, нэг мэргэжилтнээс ер нь ширээнээс цааш гарч байгаагүй ийм л юм байгаа юм.

Яг эрүүл мэндийн салбарын хүмүүс маань ч гэсэн яг энэ эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг үлгэрлэж манлайлах талаас та бүхэн маань судалгаа хийсэн ийм зүйл байна уу. Өөрсдийнхөө эрүүл мэндийн салбарын хамт олны дунд. Гэхэд би бол эргэлзээтэй тоо хэлэх байх гэж би ингэж бодож байгаа. Яагаад ийм зүйлүүдийг хэлж байна вэ гэхээр энэ хуулийн цаад талын зорилго бол төсвөөс шууд санхүүжилт авъя гэж байгаа. Тэгээд бид энэ нийгмийн эрүүл мэндийн асуудлыг бүрэн хэмжээнд хариуцна. Гадаадын зээл тусламж, хамтран ажиллах байгууллага, бүх түвшинд ерөөсөө л бид нарт энийг өгчих өө л гэж байгаа юм. Би Чинзориг сайдад ч би бас хэлээд байгаа юм. Ер нь яаман дээр ингээд очиход бол тэнд олон жил ажиллачихсан хүмүүс л мэдээллээр сайдыг хангадаг л даа.

Тэгээд наад улсууд чинь ийм байдалтай хангаад байна. Энэ хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ч гэсэн

манайхаас хүмүүс ороод бол хад мөргөнө гэдэг шиг яг л хуучин маягаараа буланд сууж байгаад л тэгээд л надад ирж танилцуулаад л байсан л даа. Би сайдтай бол яриад л байгаа юм. Яг иймэрхүү маягаар явах юм бол Их Хурлын гишүүд минь та бүхэн минь анхаарч үзээрэй. Бид нар 2, 3 парламентын бүрэн эрхийн хугацаанд хөөцөлдөж байж иргэд өөрөө эрүүл байгаагийнхаа эрүүл мэндээ өөрөө хамгаалж байгаа иргэдээ урамшуулъя гэж Эрүүл мэндийн даатгалын санд цалингаасаа төлбөр төлж байгаа, хураамж төлж байгаа тэр хураамжаасаа тодорхой хэмжээнд фитнес клубт ч байдаг юм уу, энэ эрүүл мэндийн үйлчилгээ авах, урьдчилан сэргийлэх энэ ажилд тодорхой хэмжээний зардал гаргаж, авдаг ийм тогтолцоог оруулчихсан чинь зэрэг Эрүүл мэндийн яамныхан энэ гүйцэтгэлээр санхүүжүүлдэг ийм тогтолцоо руу орж байгаа гээд нөгөөдөх юм нь хаагаад хураагаад авчихсан. 19 оны төсвийн хуулиар.

Бодит хандлага байдал бол ийм л юм байгаа юм. Тэгээд энэ дээр бол дэлхий нийтийн чиг хандлага үнэхээр энэ хөдөлгөөн гэдэг бол арга байхгүй энэ хүн амын, хүн төрөлхтний тулгамдсан ийм асуудал болчихоод байна. Олон улсын олимпын өдрийг Олон улсын олимпын хороо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтраад Let's move гэдэг ийм хөдөлгөөнийг эрхэмлэсэн ийм уриан дор явуулж байна шүү дээ. Сая энэ Бакуд олон улсын спортын сайд нарын уулзалт ЮНЕСКО байгууллага хамтраад Fit for lief гэдэг ийм хөдөлгөөн, ийм аяныг хэрэгжүүлэхээр ингээд зорьж байна. Тэгэхээр би Эрүүл мэндийн яамныхнаас тодорхой хоёрхон зүйл асуух гээд байгаа юм.

Нэгдүгээрт та нар тэр зогсоосон, хуулиар хүчингүй болгосон Эрүүл мэндийн даатгалын сангаасаа авч ашигладаг ийм бололцоог гаргаж өгөх үү. Дараагийнх нь Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн 30 хувь.../минут дуусав./

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя. Саяын асуулт, саналыг сайн судалж хариу өгөх хэрэгтэй.

С.Чинзориг: Бат-Эрдэнэ сайдын асуултад хариулъя. Ер нь бол би хэлээд байгаа нийгмийн эрүүл мэндийн асуудал гэдэг ганцхан эрүүл мэндийн асуудал биш. Энэ бол асар олон салбарын, салбар хоорондын уялдаа, зохицуулалт харьцан шаардсан асуудал. Тэр утгаараа энэ чинь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг бас салбар хоорондын уялдаа зохицуулалтыг хангаж байх Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөл нь Монгол Улсын Ерөнхий сайд бас ахалж байна гээд ингээд бид нар энэ хуулийн төслөө оруулж ирж байгаа.

Тийм учраас бол бид энэ энэ чиглэлээрээ л ажиллана. Үндэсний нийгмийн эрүүл мэндийн тус хууль батлагдвал бид энэ хүрээндээ салбар хоорондын уялдаа холбоо, асуудлыг хангаж ажиллах шаардлагатай.

Ер нь бол энэ нийгмийн эрүүл мэндийг тусламж, үйлчилгээний гол амин сүнс нь ерөөсөө иргэний өөрийнх нь оролцоог хангах тухай асуудал байгаа юм Бат-Эрдэнэ гишүүнээ. Тийм учраас бол тэр эрүүл амьдралын хэв маяг, зөв хэв маяг тогтоох асуудал, амьдралын идэвхтэй хөдөлгөөнт асуудал, нийтийн биеийн тамираар хичээллэх асуудал, хөдөлгөөнт асуултаар асуулга гээд ийм асуудлууд бий. Тийм учраас бол энэ бас хамтын цаашдаа хамтын уялдаа холбоо, салбар хоорондын зохицуулалтууд шаардсан асуудал.

Танай салбараас бол бид нар ажлын хэсэгт ажлын хэсэг болоод оруулаад ажилласан. Тэгээд танд юу гэж очиж мэдээлэл өгч, буруу зөрүү мэдээлэл өгснийг би мэдэхгүй. Манайхантай ажлын хэсэгт нь оруул гээд л ажлын хэсэг нь ороод ажиллаж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигж байсан асуудлыг Эрүүл мэндийн яам авчихсан л гээд байх юм. Тэр

чинь 19 онд Их Хурал хуульд нь хуульчлагдаж хүчингүй л болгочихсон. Өөр өөрчлөлт оруулаад л. Хэцүү шүү дээ. Тэр чинь ямар Эрүүл мэндийн яам булаагаад авчихсан биш Бат-Эрдэнэ сайд. Бид нар энэний дараагаар Эрүүл мэндийн даатгалын хууль оруулж ирнэ. Эрүүл мэндийг дэмжих, Эрүүл мэндийг дэмжих сангийн тухай хууль Улсын тусгай сангийн тухай хууль оруулж ирнэ Бат-Эрдэнэ сайд. Энэ хүрээнд бол тодорхой асуудал ярьж байгаа. Би бол танд хэлээд байгаа шүү дээ. Эрүүл мэндийн тодорхой дэмжих тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах замаар одоо бол зөвхөн эрүүл мэндийн тус сангийн тухай хөрөнгийг зөвхөн нийгмийн эрүүл мэндийн хяналт, судалгааны ажилд зарцуулж байгаа. Энийг хамрах хүрээг нь өргөжүүлж өгнө. Нийтийн биеийн тамир, идэвхтэй амьдрал, хэв маягт дасгал хөдөлгөөн хийхтэй холбоотой асуудал оруулна.

Дээр нь энэ дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношлох, эмчлэх, шинэ технологи нутагшуулахад нь зарцуулдаг болгоно гээд. Ингээд энэ Тусгай сангийн хууль яамдаас санал аваад удахгүй явж байгаа. Удахгүй Засгийн газар руу оруулна. Энэ хүрээндээ энэ таны яриад байгаа асуудлууд бас бүрэн ороод явж байгаа. Та ингээд орохгүй байна, Чинзориг намайг мурих гэж байна гээд тэгээд байгаа юм. Тийм асуудал байхгүй. Засгийн газар дээр энэ асуудал Тусгай сангийн хуулийн асуудал орж ирнэ. Тэн дээрээ бас ингээд тусгаад явна гэж бодолтой байгаа. Ийм бас байр суурьтай байх.

Г.Занданшатар: Нэг гишүүний асуулт хариултын дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр манай улс ялангуяа энэ төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал, улсын Ерөнхийлөгч, Засгийн

газраас энэ нийгмийн хэрэгцээ, шаардлага дэлхий нийтийн чиг хандлага энийг үнэхээр мэдэрч бодлогоо гаргаад байгаа юм. Ерөнхийлөгч тухайлах юм бол “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийг улс орон даяар явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд “Илүү чийрэг эртэч Монгол хүн” гээд ингээд хөтөлбөр явуулаад байдаг. Тэгээд энэ хөтөлбөрүүдийг чинь хэн зөвхөн сургалт, соён гэгээрүүлэх ийм хэлбэрээр энэ ажил чинь үр дүнд хүрэхгүй шүү дээ. Ялангуяа энэ дасгал хөдөлгөөн, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгоно гэдэг чинь хүн өөрөө цаг гаргаж, өөрөө хүсэл эрмэлзэл, тэмүүлэлтэй байж байж, өөрөө оролцож байж тэрийг чинь хэвшил болгодог ийм ажил байхгүй юу. Тэгэхээр та нар сургалт явуулна, энд бид нарт мөнгийг нь өгчих гээд ингээд байдаг.

Гэтэл улсын төсөв дээр бид нар 6 тэрбум төгрөг хуваарилуулах гэж санал өгөөд 200-хан сая төгрөг нийтийн биеийн төлбөрт хуваарилж өгч байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Баабаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг олон талаас нь ярилцаж, маш сайн ярьж гарах ёстой гэж ингэж үзэж байгаа. Энэ эрүүл мэндийн яг нийгмийн эрүүл мэндийнх нь хэд хэдэн чухал асуудал байна гэж ойлгож байгаа юм л даа. Энд нэгдүгээрт нь энэ эрүүл мэндийн тандан судлал гэж асуудал байдаг. Энэ асуудал бол бас манайд нэлээн хоцрогдчихсон явдаг гэж ингэж ойлгодог.

Дараагийн асуудал бол юу гэхээр энэ орчны болон хүнсний аюулгүй байдал гэсэн асуудал байгаа.

Гуравдугаарт нь бол юу гэхээр энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудал. Тэгээд энэ удирдан зохион байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээ удирдан зохион байгуулах гээд хэдэн асуудал дээр л их голлож анхаарч ажиллах ёстой гэж ингэж ойлгож байгаа юм л даа. Энэ

шинжлэх ухаан, технологийн ололт бол хамгийн их нэвтэрч байгаа салбар бол эрүүл мэндийн салбар гэж ингэж ойлгож байгаа. Тухайлбал хиймэл оюун ухаан. Хиймэл оюунаа ухааны тусламжтайгаар эрүүл мэндийн салбарт нэвтэрч байгаа энэ ололт амжилт дэлхийн чихийг дэлдье л гэж байна шүү дээ. Та бүгд ойлгож байгаа тиймээ.

Тийм учраас бид бол хойноос нь хөөгөөд хөгжинө гэж байхгүй. Хандаж хөгжих ёстой. Маши их зүйлийг бодож хийх ийм шаардлагууд бол үүссэн байна гэж. Улс орны хөгжил бол хүний хөгжил гэж байгаа юм. Хүний хөгжлийг ингээд аваад үзэхээр хамгийн нэгдүгээрт нь эрүүл мэндийн асуудал, эрүүл мэнддээ бид хөрөнгө оруулах ёстой. Эрүүл мэнддээ анхаарах ёстой.

Дараагийн асуудал энэ боловсролын асуудал байгаа. Энэ хоёрт л голлож, анхаарч байж улс орон хөгждөг ийм жамтай. Энэ зах зээлийн нийгмийн гол зарчим бол эрэлт, нийлүүлэлт гэж тиймээ. Эрүүл мэндийн салбарт бол эрэлт, нийлүүлэлт гэхээсээ илүү төрийн оновчтой бодлого, төрийн оновчтой зохицуулалтууд маш их шаардлагатай. Энэ эрүүл мэндийн салбар ер нь бүх салбаруудын үйл ажиллагаа яагаад ингэж доголдолтой явж байна гэхээр энэ бүх үйл ажиллагаа бол эдийн засгаараа баталгаажиг байх ёстой. Манай эрийн эрүүл мэндийн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн салбарт оруулж байгаа санхүүжилт энэ бол шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа юм.

Ийм учраас бол эдийн засгаа эрчимжүүлэх ёстой, хуримтлалтай болох ёстой. Ингэж байж улс эх орноо энэ энэ салбараа өөд нь татах ёстой гэж ингэж ойлгож байгаа юм. Хэд хэдэн асуултууд байна.

Нэгдүгээрт нь энэ зүгээр энэ завшааныг ашиглаад асуучихъя. Жил болгон маш их олон Монгол хүн энэ Солонгос, Энэтхэг, Турк гээд явж байна

шүү дээ. Энэ Монгол Улс чинь энэ элэгний хорт хавдар, ходоодны хорт хавдар, тэгээд нойр булчирхай гээд энүүгээр 10 000 хүнд ноогдох үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж байгаа юм. Яг энэ чиглэлд танайх ямар бодлого барьж байна. Монголдоо эмчлэх чиглэлээр. Тэр лабораториудыг нь байгуулдаг, тэр оношилгоог Монголдоо хийдэг болох энэ чиглэлд ер нь яамны бодлого ер нь ямар бодлого байна гэсэн нэг дэх асуулт байна. Маш тодорхой хэллээ шүү дээ тэд. Тэд тэдэн онд ингэнэ.

Хоёр дахь асуудал бол юу гэхээр энэ энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулдаг санхүүжилт эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хэдэн хувийг эзэлж байна. Хоёр дахь асуудал. Яг тодорхой тоо хэлээч.

Гурав дахь нь энэ Улаанбаатар хотод маш их хэмжээний бороо орж байна. Бид бол үер ус гээд л ингээд л бодоод байдаг. Энэний цаад талд хамгийн аймшигтай юм энэ хөрсний бохирдол гэдэг юм байж байгаа. Энийг дамжиж хорт, халдварт өвчин гарах эрсдэл аягүй өндөртэй болчихсон. Энэ эрсдэлийг та нар яаж тооцож байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Ер нь бол жилд маш олон иргэд маань дотоодод оношилж амжиж чадахгүй байгаа өвчний улмаас гадаад улсад бас эмчилгээ оношилгоонд хамрагдаж байгаа иргэдийн санхүүгийн асар их дарамтад оруулж байгаа ийм асуудлууд байна. Дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байна гээд Баттөмөр гишүүн энэ 26 өвчний жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан байдаг байна.

Гэхдээ энэ дээр шүүмжлэлтэй хандаж байгаа юм нь хоёр юм байгаа юм. Нэг дэх асуудал нь нэгэнт дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байна гээд

сайд нь тушаал гаргаад энэ өвчнөө зарлачихсан бол тэгвэл энэ өвчнөөр өвчлөөд шаналж байгаа гадагшийгаа эмчилгээ оношилгоонд явж байгаа иргэддээ ямар туслалцаа дэмжлэг байна вэ гэхлээр байхгүй болчихоод байгаа юм. Гадагшийгаа яваад эмчлүүлээд ирсэн бол тэр гадаадад гарсан эмчилгээнийх нь зардлын 5-хан хувийг л өгнө гэдэг ийм журамтай.

Тэгэхээр энэ бол бас өөрөө дотооддоо оношилж, эмчилж чадахгүй гэж төр хэлчээд тэгээд гадагшаа яваад ирж байгаа эмчлүүлээд ирэхэд нь зардлынх нь 5-хан хувийг өгнө гэдэг бол энэ бол бас маш үр дүн муутай. Энийг бол нэлээн бас эргээж харах ёстой гэсэн ийм бодол бодолтой байгаа юм.

Хоёр дахь асуудал нь бид би түрүүн хэлсэн тэр Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал хуулийн төслүүд явж байгаа. Ингээд Их Хуралд оруулж ирнэ. Одоогийн тэр Тусгай сангийн тухай хуулиар эрүүл мэндийг дэмжих сантай байна. Архи, тамхины онцгой татвар 1-2 хувийг нь тэр сан бол бүрддэг. Тэр санг зөвхөн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр буюу судалгаа, сурталчилгааны ажил хийхэд зарцуулаад байгаа юм. Энийг өргөжүүлж энэ дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнийг эмчлэх, оношлох шинэ технологи нутагшуулах зардлыг энэ сангаас бас санхүүжүүлдэг болгоё гэсэн ийм чиглэлээр хуульчилдаг, хуулийн өөрчлөлт оруулж байгаа юм. Энэ жил би харьяа эмнэлгийн дарга нарт үүрэг өгөөд Шинжлэх ухаан, технологийн сангаас энэ дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнийг эмчлэх, нутагшуулах, технологи нутагшуулах чиглэлээр төсөл бич гэж ийм чиглэл өгөөд манайх 10 өвчнийг эмчлэх, технологи нутагшуулах төсөл Шинжлэх ухаан, технологийн санд өгсөн байгаа. Энэ төслүүдийг дэмжүүлэх талаар нийтдээ бол бид нэлээн бас эрчимтэй ажиллаж байна.

Хоёр дахь асуудлын тухайд ер нь бусад өндөр хөгжилтэй орнуудыг харахлаар энэ нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж, үйлчилгээндээ санхүүжилтийнх нь 50-60 хувийг нь хуваарилдаг ийм турилага бол байна. Манайх бол үүний эсрэг болчихоод байгаа юм. Өнөөдөр бидний, нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж, үйлчилгээнд санхүүжилтийнх нь дөнгөж 19-хөн хувийг л зарцуулж байна шүү дээ. Тэгэхээр энэ нь энэ бол бид нар олон улсын хөгжлийн чиг хандлагын эсрэг болчихоод байна.

Тийм учраас энийг бас өөрчлөхийн тулд энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг оруулж ирж байгаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэдгийг нь бүүр тодорхой болгож бол оруулж ирж байна.

Сүүлийн өдрүүдэд энэ Улаанбаатар хотод бороо их орсонтой холбоотойгоор бас үерийн байдалтай байна. Онцгой комисс сая 2 цаг, 3 цагаас хуралдсан. Эрүүл мэндийн сайдад хоёр чиглэл, үүрэг өгсөн. Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах.

Хоёр дахь асуудал нь энэ үерийн улмаас орчны бохирдол бас нэлээн бий болно. Энэнтэй холбоотойгоор ариутгал, орчны бохирдлын бас ариутгал хийх, халдваргүйжүүлэх ийм бас арга хэмжээ авах гэсэн ийм үүрэг өгсөн. Энэний дагуу сайдын тушаал гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудыг энэ үерийн үед бэлэн байдлаар ажиллуулах, нөгөө талдаа энэ орчны ариутгал, халдваргүйдэл хийх ийм чиглэлийн тушаал гаргаад ажиллуулж ингэж тодорхой бас үр дүн гарах гарах болов уу гэж найдаж байна. Энийг нэлээн онцгой анхаарч ажиллахгүй бол маш олон халдварт өвчний эх суурь бас болох ийм бас магадлалтай гэж бид маш бас болгоомжилж, нэлээн хүн хүчээ нэлээн хуваарилж бас дайчилж ажиллагаанд оруулж байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн 1 минут тодруулж асууя.

Б.Баттөмөр: Энэ бодлого, хөрөнгө оруулалтыг Монгол Улсын хэмжээнд эрэмбэлэх юм бол нэгдүгээрт нь энэ эрүүл мэндийн салбарт өгөх ёстой. Эрүүл байж байж энэ Монгол хүн эрүүл байж байж хөгжлийн тухай ярина шүү дээ. Түүнээс биш нэг сумд аваачаад 100 км, 1 км зам бариад байх бол хөгжил бол биш шүү. Нэгдүгээрт энийг хэлье гэж.

Хоёрдугаарт энэ гадагшаа явж байгаа энэ Монголд эмчилж чадахгүй байгаа юуг Монголд эмчлэх хэрэгтэй. Гадна эмчлээд байгаа шүү дээ. Энийг Монголд нутагшуулах ёстой. Тэр хөрөнгө оруулалтууд тэр тавьж байгаа янз бүрийн хэрэгтэй, хэрэггүй хөрөнгө оруулалтуудыг энд тавих ёстой. Хамгийн нэг номерын асуудал энэ шүү. Энийг хэлье гэж бодож байгаа юм. Ялангуяа тэр бид нар чинь их нээлт хийх гэж байгаа биш дээ. Шинэ технологи нутагшуулах гээд сая сайдын үгэнд гарч байгаа. Гол асуудал энэ шүү дээ. Бидэнд бас боломжууд байна шүү дээ. Элэг шилжүүлэн суулгах барих дээр чинь тодорхой амжилтад хүрчихсэн байдаг юм байна лээ шүү дээ. Тийм учраас энд л хамгийн түрүүлж анхаарах ёстой л гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал

хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдэж, төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул уг төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийн асуудалд орно.

18.19 цаг

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Улсын Их Хурлын 32 гишүүн 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Төсвийн хэлэлцүүлгийг 3, 8 дугаар сард хийхээр хуулийн төсөлд тусгасан байсныг зөвхөн 8 дугаар сард хийх, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх 14 хоногоос өмнө хийх.

2.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамагт үндэслэнэ гэж тогтоосныг өөрчилж төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалыг харгалзан Эдийн засаг, хөгжлийн яам нь холбогдох тооцооллыг хийх талаар өөрчлөлтийг тусгах.

3.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг Төсвийн байнгын хороо томилох, чөлөөлөх гэснийг Улсын Их Хурал томилох, чөлөөлөх гэж өөрчлөн холбогдох томилгоо хийх, сонсгол зохион байгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхээр өөрчлөх.

4.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг өөрчлөх, хэрэгжих хугацааг хойшилох зэрэг хуулийн төслийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн хуралдаанд нийт гишүүн хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно гэж заасныг Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд

заавал хүрэлцэн ирж оролцоно гэж хуульд нийцүүлэн тодорхой болгох.

5.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, төсвийн цаглаврыг мөрдүүлэхтэй холбогдсон зүйл, хэсэг, заалтыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 25 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөх журмын хуульд холбогдох өөрчлөлтийг тусгасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 47 санал байгаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8.1.1¹ дэх заалтын дугаарыг “8.1.2” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.7¹ дэх заалтын дугаарыг “8.4.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ганибалын Амартүвшин, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Хүрэлбаатарын Булгантуяа, Сайнхүүгийн Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Болдын Жавхлан, Лхагвын Мөнхбаатар, Салдангийн Одонтуяа, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн. Цаашид Төсвийн байнгын хороо гэнэ. Санал хураалт.

Баттөмөр гишүүн байсан алга. Болорчулуун, Бямбацогт ... хэд үү. Хассуурийн Ганхуяг, Туваан байхгүй. Баделхан, Сүхбаатар, Болорчулуун, Бямбацогт, Даваасүрэн, Дамдинням, Өнөрболор, Раднаасэд, Цогтгэрэл, Цэрэнпунцаг. Энд уг нь 20 хүн байна л даа. Карт ч уншигдаагүй юм байна. Тэгээд санал хураах уу. Пүрэв-Очирын Анужсин гишүүн.

П.Анужсин: Миний карт ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү. Санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Төсвийн байнгын хорооны дарга энэ Мөнхбаатар гишүүнийг дуудна. Наранбаатар байна, Оюунчимэг байна, Пүрэвдорж, Сандаг-Очир, Сүхбаатар, Сэргэлэн, Тогтохсүрэн, Тэмүүлэн, Чинбүрэн, Чинзориг. Эсрэг

гараад байгаа Аубакир, Баделхан, Сүхбаатарын Батболд, Баагаагийн Баттөмөр гишүүн сая байсан. Болорчулуун, Бямбацогт байсан. Хассуурийн Ганхуяг, Дамдинням, Мөнхбаатар, Өнөрболор, Раднаасэд, Туваан, Цогтгэрэл.

Ингээд Анужсин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Чинзориг сайд санал хураалт. Анужсин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Жигжидийн Батжаргал, Гонгорын Дамдинням нарын санал дэмжсэн боловч эсрэг гарсан гэсэн санал гаргаж байна. Ингээд Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Саяын томъёоллоор санал хураалт явуулахад дэмжсэн санал өгсөн ч эсрэг гараад байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Одоо чинь энэ хурууны хээний технологи хоцрогдоод бас заримдаа энэ юу алдагдаад байх юм бас. Энэ бас хуучирчихсан л даа зайлуул. Ингээд санал хураалт явуулъя. Батжаргал гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учир санал хураалтыг дахиж явуулъя.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 10.5 дахь хэсгийн “санхүүжүүлэх, хянах, тайлагнахад төслийн кодыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэж, төсвийн төлөвлөлтөд тусгана.” гэснийг “санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон төрийн болон орон нутгийн өмчид

бүртгэхдээ төслийн кодыг үндэслэнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хэсгийн дугаарыг “11¹ дүгээр зүйл” болгон өөрчлөх:

“11¹ дүгээр зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүний бүрэн эрх

11^{1.1}.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12².1-д заасны дагуу боловсруулсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хэсгийн дугаарыг “12² дугаар зүйл” болгон өөрчлөх:

“12² дугаар зүйл.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

12^{2.1}.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулна.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Төсвийн хүрээний мэдэгдлийг чинь Сангийн яам боловсруулдаггүй юм уу. Төсвийн хүрээний мэдэгдлийг үү. Санал хураалт. Энэ ер нь бас л явдалтай л юм байна.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэгэхдээ энийг тэгвэл бусад хуульдаа янзлахгүй бол Төсвийн хүрээний мэдэгдлийг чинь Сангийн яам боловсруулж, Улсын Их Хурал, Засгийн газарт өргөн мэдүүлээд, Засгийн газар хэлэлцүүлээд, Засгийн газар баталж байгаа шүү дээ.

Ер нь бүх юман дээр тэгээд л сангийн асуудал, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гээд л заачихсан байгаа.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 24.7 дахь хэсгийн “өмчийн оролцоотой” гэсний өмнө “төрийн болон орон нутгийн” гэж, мөн хэсгийн “ногдох хөрөнгийг” гэсний өмнө “болон орон нутагт” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн санал.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр саналуудаа яриад макро эдийн засгийн үзүүлэлтээ тохирч болно. Сангийн яам төсвийн орлого, зарлага энэ тэр дээрээ тооцоолж байж Төсвийн хүрээний мэдэгдлээ боловсруулна шүү дээ. Төсвийн алдагдал, төсвийн орлого, зарлагыг чинь Сангийн яам төлөвлөх ёстой биз дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл чинь тэднүүс бүгд орно шүү дээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 27.1.10 дахь заалтын “ирээдүйн өв сангийн дансны үлдэгдлийн мэдээллийг” гэснийг “Ирээдүйн өв сангийн үлдэгдлийн хэмжээг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28^{1.2} дахь хэсгийн “жил бүрийн 3, 8 дугаар сард багтаан” гэснийг “жил бүрийн 8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28^{1.2.1} дэх заалтын “асуудал” гэсний өмнө “салбарын гэж нэмэн, 28^{1.2.2} дахь заалтын “нийгмийн халамж, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин зэрэг” гэснийг болон 28^{1.2.3} дахь заалтын “зэрэг шинжтэй” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28^{1.3} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28^{1.3}.Энэ хуулийн 28^{1.2}-т заасан төсвийн тодотголд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр боловсруулах төсвийн тодотгол хамаарахгүй.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 28¹ дүгээр зүйлийн 28^{1.4} дэх хэсгийн “төсөл, түүний нэмэлт, өөрчлөлтийн” гэснийг хасаж, “3 дугаар сард багтаан энэ хуулийн 28^{1.1}-д заасан журмаар” гэснийг “3 дугаар сард багтаан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт

оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 32.2.22 дахь заалтын “шийдвэрлэсэн талаар танилцуулгад тусгана.” гэснийг “тусгасан талаарх мэдээлэл;” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийг хасаж, 70.2 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага болон холбогдох” гэснийг “удирдах болон гүйцэтгэх” гэж, мөн хэсгийн “28^{1.3}” гэснийг “28^{1.4}” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийг хасаж, 70.2 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага болон холбогдох” гэснийг “удирдах болон гүйцэтгэх” гэж, мөн хэсгийн “28^{1.3}” гэснийг “28^{1.4}” гэж өөрчлөх. Саяын уншсан.

13.Төслийн 2 дугаар зүйлийн “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8” гэсний дараа “, 28.3.12” гэж,” гэснийг хасаж, үүнтэй уялдуулан төслийн 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэснийг “28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “28.3.8-д” гэснийг “28.3.8, 28.3.12-т” гэж, мөн зүйлийн” гэж өөрчлөн, 2 дугаар зүйлийн ““санхүүжилтийн эх үүсвэрээр” гэсний дараа “анхны төсөвт өртөг, код” гэж” гэснийг ““төсөвт өртөг,” гэсний дараа “анхны төсөвт өртөг,” гэж” гэж

өөрчлөх. Санал гарсан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүд байгаа дээр тэр нэг зүйл зарлаадахъя. Сүхбаатар дарга аа Сүхбаатар гишүүн ээ Хууль зүйн байнгын хороо, Үнэнбат дарга, Мягмар дарга чуулганы дараа хуралдах хэрэгтэй байна. Тийм, Энхбаяр гишүүн ярьсан уу. Та хоёр зохион байгуулаадхаач. Тийм, тэр чинь нөгөө хоёр чинь байхгүй болчихоод онгоц нь саатчихаад бүүр болохоо болиод байна. Нүүрсний хулгайн асуудлаар түр хороо байгуулах асуудлыг өргөн барь... Хууль зүйгээр явна биз дээ. Тэгж байж бэлтгэлийг нь хангаж энэ 9 сард хийх ажил зохион байгуулагдахгүй бол.

15.Төслийн 3 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.3, 8.4.4, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг” гэснийг “дараах хэсэг, заалтыг” гэж, 6 дугаар зүйлийн “хэсгийг” гэснийг “заалтыг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар зүйлийн “55 дугаар зүйлийн 55.4.2 дахь заалтын “ирэх” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан” гэснийг хасах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Маргааш өглөө 9-өөс хуралдаж чадах уу. Хууль зүйн байнгын хороог маргааш 9-өөс зарлахаар зохион байгуулчих. Хууль зүй юу, Эдийн засаг уу тэрнийхээ. Маргааш Эдийн засаг хуралдах билүү. Тогтохоо даргатай яриад Эдийн засгийн байнгын хороог тавьчих. Танайх яахаар байна. Танайх чинь хэн хэн хэн байдаг юм. Сандаг-Очир гишүүн байна. Байхгүй. Батжаргал, Амартүвшин, Булгантуяа, Батсуурь, хөөш Булгантуяа сайдаа гишүүнээ

маргааш Төсвийн байнгын, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооныхоо ирцийг Тэмүүлэн дарга та хоёр бүрдүүлж, өглөө 9-өөс хуралдахгүй бол төсвийн гүйцэтгэлээ баталж чадахгүй болох нь байна шүү. Тэгвэл чуулган завсарлахгүй 13-нд, 17-нд амралтын өдөр байгаа юу. 17-нд хуралдана чуулган хуралдана.

Ер нь 7-нд завсарлахаа тэгээд болих тийшээ л хандъя даа тээ.

17 юу. 16. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8.1.1 дэх заалтын “боловсруулсан” гэснийг “ирүүлсэн” гэж, “дүн шинжилгээ, тооцоонд” гэснийг “таамаглалд” гэж тус тус өөрчлөн, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 8.4.3 дахь заалтын “, шаардлагатай тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн жилийн төсөвт баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тус тус боловсруулж” гэснийг хасах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 8.4.4 дэх заалтын “холбогдох макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан нэгтгэн боловсруулж, хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэхэд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэснийг “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 4 дүгээр зүйлийн “10-ны” гэснийг “9-ний” гэж өөрчлөн, “8.4.3 дахь заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж,”

гэснийг хасах. Санал гаргасан Төсвийн байнга хороо. Санал хураалт.

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 4 дүгээр зүйлийн “чуулган эхлэх өдрөөс эхлэн хэлэлцэн” гэснийг “чуулганаар хэлэлцэн” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 4 дүгээр зүйлийн “28.2,” гэснийг хасаж, “28.1” гэснийг “29.1” гэж өөрчлөн, “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.1.2-8.1.4 дэх заалтын дугаарыг “8.1.3-8.1.5” гэж, 8.4.8 дахь заалтын дугаарыг “8.4.9” гэж” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “түүний” гэснийг хасаж, “бүрийг кодоор” гэснийг “бүрийн код” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хэлэлцээр батлахаас” гэснийг “хэлэлцээрээс” гэж, 2 дугаар зүйлийн “38.8 дахь” гэснийг “38.9 дэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.1 дэх заалтын “зээлийн зориулалт нь” гэснийг “зээлийн зориулалтыг тодорхой тусгасан эсэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Ганбат гишүүн, Пүрэвдорж гишүүнээ одоо энэ удахгүй дуусна. 20-хон санал хураалттай. Ойлгосон би тэгээд.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.2 дахь заалтын “төсөл, арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцсэн эсэх” гэснийг “төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл, хөтөлбөр байх” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэг.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.3 дахь заалтын “Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх” гэснийг “улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт болон зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн байх” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Энэ их чихэнд чимэгтэй заалт байна шүү. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 75¹ дүгээр зүйлийн 75¹.3.4 дэх заалтын “нөлөөлөхгүй” гэсний дараа “, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт” гэсний өмнө “хэсэг,” гэж нэмэн, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 6.4.8 дахь заалтын “зардлын хяналтыг” гэснийг “гүйцэтгэлийн хяналтыг” гэж өөрчлөн, 3 дахь заалт буюу 6.5.3 дахь заалтын “хэлэлцээр” гэсний өмнө, 5 дахь заалт буюу 13.2.5 дахь заалтын “хэлэлцээрийн” гэсний өмнө “гэрээ,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.5.4 дэх заалтын “Монгол Улс шинээр зээл авах” гэснийг “энэ хуульд заасны дагуу улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах” гэж, мөн заалтын “зэрэг мэдээллийг нэгтгэсэн байдлаар” гэснийг “зэргийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 18.11 дэх хэсгийн “тооцоолол” гэснийг “тооцоо, судалгаа” гэж өөрчлөн, “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн” гэсний өмнөх “Монгол Улсын шадар сайд,” гэснийг хасах. Санал

гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн “13.2.3” гэснийг “13.2.2” гэж өөрчлөн, 3 дугаар зүйлийн “тогтоосон” гэсний өмнө “талаар” гэж, “дэлгэрэнгүй” гэсний өмнө “талаарх” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмэн, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 8.8 дахь хэсгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн” гэснийг “Нэгдсэн төсвийн” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энийг яаралтайгаар авчих.

2.Төслийн 3 дугаар зүйлийн ““өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлэх” гэж” гэснийг “Монгол Улсын жилийн төсвийн” гэсний болон “жилийн төсвийн төсөлд” гэсний өмнөх “өргөн мэдүүлсэн” гэснийг “өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

61.5 хувийн санал дэмжигдлээ.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “, заалт” гэснийг хасаж, мөн зүйлийн 1 дэх заалт буюу 6.5 дахь хэсгийн “эцсийн хугацааг” гэснийг “хугацааг” гэж, мөн

зүйлийн 2 дахь заалт буюу 7.5 дахь хэсгийн “3 сараас доошгүй хугацаанд төсвийн төсөл” гэснийг “гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.6 дахь хэсгийн “Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гамшиг бүхий нөхцөл байдал бий болж төсөв болон” гэснийг “Гамигийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах зорилгоор жилийн төсөв болон” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 7.7 дахь хэсгийн “хэлэлцэх Улсын Их Хурлын байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн чуулганд нийт гишүүн хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэснийг “хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно.” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.1 дэх хэсгийн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, “үзүүлэлтийн төсөөллийг” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16¹.2.Зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.3.2 дахь заалтын “идэвхтэй” гэснийг, 16¹.3.3 дахь заалтын “улс төрийн” гэснийг тус тус хасаж, 16¹.4.4 дэх заалтын “үр дүнгийн талаар сонсгол зохион байгуулж хамгийн өндөр үнэлэмж авсан” гэснийг “үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 16¹.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэн, үүнтэй уялдуулан 16¹.4.5, 16¹.4.6, 16¹.4.7, 16¹.4.8 дахь заалт, 16¹.5, 16¹.6 дахь хэсгийг тус тус хасах:

“16¹.4.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.8 дахь хэсгийн “Төсвийн байнгын хорооны шийдвэрээр” гэснийг “Улсын Их Хурал” гэж, 16¹.9 дэх хэсгийн “үзүүлэлтийн тооцоолол” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг” гэж, 2 дугаар зүйлийн “үзүүлэлтийн төсөөлөлд” гэснийг “үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд” гэж тус тус өөрчлөн, уг хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“16¹.6.7.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 16¹.11 дэх хэсгийн “тогтоох итгэлцүүрийг” гэснийг болон 16¹.12 дахь хэсгийг тус тус хасаж, 16¹.3.7 дахь заалтын дугаарыг “16¹.10.” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжидлээ.

8.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.3 дахь” гэснийг “8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.5 дахь” гэж өөрчлөн, 8.3 дахь хэсгийн “дансанд” гэсний дараа “Сангийн эх үүсвэрийг” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “10.7, 10.8,” гэснийг “10 дугаар зүйлийн 10.8, 10.9 дэх хэсэг” гэж, мөн зүйлийн “24.15.5” гэснийг “25.14.5” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн 5, 16, 21 дүгээр зүйлд хуульд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг,” гэснийг “, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг” гэснийг “болон төсвийн алдагдлыг” гэж тус тус өөрчлөн, мөн хэсгийн болон 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21 дэх хэсгийн “тусламж” гэсний дараа “, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ,” гэж тус тус нэмэн, 21 дэх хэсгийн “төсвийн алдагдал нөхөх зэрэг аливаа хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг” гэснийг “төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

61.5 хувийн саналаар санал дэмжлээ.

10.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг

боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, төсвийн цаглаврыг мөрдүүлэхтэй холбогдсон зүйл, хэсэг заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ 24 оноос дагаж мөрдөх байсан юм бол ингээд энэ биднийг наадмын өмнө шахаж яах гэсэн юм. Намар л хэлэлцэхгүй. Явж явсаар байгаад хамгийн сүүлд нь ийм санал хураалгах байсан юм уу.

11.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1.Төслийн 1 дэх заалтын “16^{1.4} дэх” гэснийг “16¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт мэдүүлэхээр Төсвийн байнгын хороо шилжүүлж байна. Дараагийн асуудалд оръё.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх 24 саналтай юм байна.

Хууль санаачлагч, хариуцсан яаманд байхгүй учраас энэ асуудлыг хойшлуулъя.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

19.07 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

